



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
http://www.parliament.mn

2026. 04. 14 № ТТ-01/391

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Р.СЭДДОРЖ ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас “Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан”, “Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан”-д хийсэн дүн шинжилгээг хүргүүлж байна.

Хавсралт ³⁸ хуудастай.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Л.ӨЛЗИЙСАЙХАН

26000536



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026 он

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохилцуулах хорооны дүрэм”-ийн 4.3-т заасныг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) нь 2025 оны Санхүүгийн салбарын тойм, 2025 оны үйл ажиллагааны тайлан болон системчилсэн үнэлгээний тайланг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/1148 дугаар албан бичгээр, Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2025 оны тайланг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 18 дугаартай албан бичгээр тус тус Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасныг үндэслэн Хорооноос ирүүлсэн тайланд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар дүн шинжилгээ хийлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан чиг үүргийн дагуу:

- санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах
- санхүүгийн үйлчилгээг зохицуулах
- холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад гарсан үр дүнг хураангуйлан дүгнэсэн.

Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхээр Хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, 5 зорилго, 4 зорилт, 21 дэд зорилт дэвшүүлж, 160 арга хэмжээг тусгасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн уялдуулсан талаар шинжилгээ хийж үзвэл:

Дээрх хуулийн

• 6.1.1-д заасан “санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих” бүрэн эрхийн хүрээнд 92 арга хэмжээ;

• 6.1.2-т заасан “бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох” бүрэн эрхийн хүрээнд 21 арга хэмжээ;

• 6.1.3-т заасан “санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл /цаашид “зөвшөөрөл” гэх/ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих” бүрэн эрхийн хүрээнд 1 арга хэмжээ;

• 6.1.4-т заасан “зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагааг шалгах” бүрэн эрхийн хүрээнд 14 арга хэмжээ;

• 6.1.6-д заасан “зөвшөөрөл эзэмшигч хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх” бүрэн эрхийн хүрээнд 6 арга хэмжээ;

• 6.1.9-д заасан “зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих” бүрэн эрхийн хүрээнд 3 арга хэмжээ;

• 6.1.10-т заасан “зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих” бүрэн эрхийн хүрээнд 2 арга хэмжээ;

• 6.1.12-т заасан “технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор турших, нэвтрүүлэх сэндрокс зохицуулалтын орчинг бий болгох, холбогдох зохион байгуулалтын нэгж, зөвлөл байгуулах зэрэг харилцааг зохицуулсан Сэндрокс зохицуулалтын журмыг санхүү, төсвийн асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих” бүрэн эрхийн хүрээнд 2 арга хэмжээ;

• 6.1.13-т заасан “иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” бүрэн эрхийн хүрээнд 15 арга хэмжээ тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Уг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний **шалгуур үзүүлэлтүүд нь гүйцэтгэлийг тодорхой хэмжээнд хэмжих боломжтой** байна, зарим шалгуур үзүүлэлтүүд “үр дүн”-г бус, зөвхөн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжихэд чиглэсэн байгаа нь бодит үр дүнг хэмжихэд хангалтгүй төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтэд хийсэн чанарын шинжилгээ

Давуу тал	Сул тал
<p>1. Зарим шалгуур үзүүлэлтээр “... тоо”, “... хувь”, “... хамрагдсан байгууллага” гэх мэт гүйцэтгэлийг тоо хэмжээний үзүүлэлтүүдээр хэмжихээр тодорхойлсон.</p> <p>2. Зарим шалгуур үзүүлэлтийн хувьд “...улирал, жил”-ээр тайлагнах боломжтойг тооцсон буюу хугацаатай уялдуулсан байна.</p> <p>3. Зарим шалгуур үзүүлэлтийг хяналт шалгалт, зөвшөөрлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг тодорхой түвшинд хэмжих боломжтойгоор тодорхойлсон байна.</p>	<p>1. Зарим шалгуур үзүүлэлтүүд үр дүнг бус, үйл ажиллагаа хэмжихэд тохиромжтой шалгууруудыг сонгосон нь “шалгалт хийсэн тоо”, “журам баталсан байх”, “сургалт зохион байгуулсан” зэрэг хийж гүйцэтгэсэн эсэхийг хэмжих ба “ямар үр дүн”-д хүрсэн, ямар нөлөө үзүүлсэн бэ? гэдгийг хэмжих боломжгүй нөхцөлийг үүсгэсэн.</p> <p>2. Чанарын үзүүлэлтийг дутуу тооцож тодорхойлсон. Жишээ нь: “гомдол шийдвэрлэсэн тоо” гэсэн шалгуур үзүүлэлт нь “шийдвэрлэлтэд сэтгэл ханамжтай байсан хувь”, дахин гомдол гаргасан хувь” зэрэг үр дүнг тодорхойлж чадахгүй.</p> <p>3. Үр нөлөөг хэмжих логикгүй байна. Хорооны үйл ажиллагааны гол зорилго нь “санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах” юм. Гэтэл энэ зорилгод хүрэхэд тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд “санхүүгийн зах зээлийн эрсдэл буурсан эсэх”, “алдаа зөрчил буурсан эсэх”, “хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдсэн эсэх”-ийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлоогүй байна. Жишээ нь: 10 шалгалт хийх гэж төлөвлөөд түүний үр дүнг 10 шалгалт хийгдсэн бол 100 хувь гэж үнэлснээр шалгалт чанаргүй байсан ч 100 хувь болох нь үр дүнг илэрхийлэхгүй.</p>

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг хэрхэн тодорхойлж батлуулсан талаар товч дурдвал:

Хэмжихдэхүйц шалгуур үзүүлэлтийн жишээ

1. “Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплайнсын шаардлагыг хангах зорилгоор “Комплайнсын менежментийн тогтолцоо ISO 37301” стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангах” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “мэдээлэл сурталчилгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тооны өсөлт” гэж;
2. “Сервер компьютеруудын найдвартай ажиллагааг хангах, түүн дээрх системүүдийн ачааллыг тэнцвэртэй байлгах” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “системүүдийн тасралтгүй ажиллагааг 95%-с дээш болгох” гэж;
3. “Дотоодын аж ахуйн нэгжээс үнэт цаас гаргахад бодлого, зохицуулалтаар дэмжих” арга хэмжээний шалгуурыг “Үнэт цаасны арилжааны дүнгийн өсөлт”-өөр хэмжихээр төлөвлөсөн нь оновчтой төлөвлөлт болсон байна.

Хэмжих боломжгүй шалгуур үзүүлэлтийн жишээ

1. “Ногоон санхүүжилтийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх” арга хэмжээний шалгуурыг “сургалтын тоо” гэж;
2. “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавих нөхиөл, шаардлагыг тогтоохтой

холбогдох журмыг батлах” гэсэн арга хэмжээний шалгуурыг “Журам баталсан байх” гэж;

3. “Зохицуулалтын байгууллагууд технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих” арга хэмжээний шалгуурыг “Технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ авсан иргэдийн тоо”-оор хэмжихээр төлөвлөсөн нь гарсан үр дүнг үнэлэхэд учир дутагдалтай хэмжүүр болсон гэж үзлээ.

Иймд гүйцэтгэлийг илүү бодитой үнэлэхийн тулд үр дүн, үр нөлөөг тоон болон чанарын үзүүлэлтээр цогцоор нь хэмжих шаардлагатай байна.

НЭГ.ХУУЛЬ, ТОГТООМЖООР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

1.1. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд:

Хороо 2025 онд “Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих, шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох” зорилго тавьж 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан байна.

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 29 хууль, 51 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулан, зохицуулалтын салбаруудын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд үнэт цаасны чиглэлээр 4 акт шинээр баталж, 6 акт шинэчлэн боловсруулж, 4 актад нэмэлт өөрчлөлт оруулж, 9 актыг хүчингүй болгосон байна. Даатгалын салбарын 2 актыг шинэчлэн боловсруулж, 2 актыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Банк бус санхүүгийн байгууллагатай холбоотой 4 актыг шинэчлэн боловсруулж, 2 актад нэмэлт өөрчлөлт оруулж, 2 актыг хүчингүй болгосон байна. Нийт 21 удаагийн хуралдааныг зохион байгуулж “шинээр” 4 журам, “шинэчлэн” 9 журам, 10 журамд “нэмэлт өөрчлөлт оруулсан”, “хүчингүй болгосон” 10 журам, “хамтарсан тушаалаар” 1 журам, “зөвшөөрөл олгосон” 1 журам тус тус баталсан байна.

Үүнээс харахад Хороо санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах, зохицуулалтын шинэчлэлийг хийх чиглэлээр идэвхтэй ажилласан байна.

Хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан “салбар бүр дэх хяналт хариуцлага, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд даатгалын салбарын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтын орчинг бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх” хүрээнд:

Даатгалын салбарын оролцоог нэмэгдүүлэх суурь эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. Үүнд, Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, даатгалын багц дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан, даатгалын үйл ажиллагааны зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэхээр ажилласан зэргээс тодорхойлогдож байна.

Мөн энэ салбарт олон улсын байгууллагуудтай ажиллах хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна. Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага, тогтвортой байдлыг бэхжүүлэх, байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг дэмжих замаар тогтвортой, ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Олон улсын санхүүгийн корпорац(ОУСК)-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж ажилласан байна. Даатгалын баталгааны зах зээлийг хөгжүүлэх, эрсдэлийн удирдлага болон мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээр БНСУ-ын Сөүлийн баталгааны даатгалын газрын удирдлагуудтай уулзалт хийсэн, олон улсын уулзалт, форумд оролцсон, бусад олон улсын байгууллагуудтай туршлага солилцсон зэргээр гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлснээр эрх зүйн суурь орчныг бүрдүүлэхэд анхаарал хандуулсан байна.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулахыг зорьж, энэ хүрээнд “Даатгалын багц дүрэм”-ийн 1, 2, 9, 10, 12 дугаар хавсралтаар баталсан журмуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулан олон нийтийн санал авах шатанд явж байна.

Эрүүл мэндийн мэргэжлийн хариуцлагын даатгал, Ипотекийн даатгал, урт хугацааны даатгал гэх зэрэг бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэх нь даатгалын салбарын эрсдэлийн хамгаалалтын хүрээг өргөжүүлж, санхүүгийн зах зээлд оролцох оролцоог

нэмэгдүүлэхийн зэрэгцээ олон улсын жишигт нийцсэн даатгалын тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой тул дээрх шинэ даатгалын төрлийг нэвтрүүлсэн нь даатгалын үйлчилгээний хүрээг нэмэгдүүлсэн байна.

Даатгалын баталгааны механизм нэвтрүүлж, Хорооны 2023 оны 46 дугаар тогтоолоор "Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам"-ыг баталсны дагуу даатгалын компаниуд 2024 оны 8 дугаар сараас эхлэн баталгаа гаргаж эхэлсэн бөгөөд 2025 оны байдлаар 10 даатгалын компани нийт 611.8 тэрбум төгрөгийн баталгаа гаргаж, 19.8 тэрбум төгрөгийн баталгааны гэрээний төлбөр төвлөрүүлсэн байна.

Ипотекийн даатгалын хамгаалалт хангалтгүй байсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Даатгалын багц дүрэм"-д өөрчлөлт оруулж, зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалыг урт хугацааны даатгалд төвлөрүүлэх зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Энэ зохицуулалт 2025.08.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар 5,440 шинэ гэрээ байгуулагдсан байна.

Даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, эрсдэлийн удирдлагад суурилсан зохицуулалтыг нэвтрүүлэх, олон улсын жишигт нийцсэн даатгалын бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь даатгалын үйл ажиллагааны зохицуулалтыг олон улсын жишигт ойртуулах бодит алхмууд болж, ахиц гаргасан байна.

Хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан "Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэл" хэлэлцүүлгийг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд:

Санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, комплайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг бий болгох, түүнийг хэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах хүрээнд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэлийн үнэлгээний сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

Хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодекс"-ыг шинэчилснээр нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлэлийн үйлчилгээ эрхлэгч, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүрэгтэй болсон.

2025 оны 2 дугаар улирлын байдлаар "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс хувьцаат компаниудын хувьд дунджаар 62.0 хувь буюу 5.4, даатгагч, Банк бус санхүүгийн байгууллага (цаашид ББСБ гэх), хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид ХОМК гэх), виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид ВХҮҮ гэх)-ийн салбар дунджаар 75.3 хувь буюу 1.3 хувиар өмнөх оны мөн үеэс тус тус өссөн байна¹.

"Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 52 дугаар тушаалаар баталсан "Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу зохицуулалттай дөрвөн салбар (даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-т Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийж нэгдсэн тайланг олон нийтэд ил тод мэдээлж ажилласан байна.

Санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох хүрээнд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн үр дүнд салбарын оролцогчдын комплайнсын ойлголт, мэдлэгийн түвшин дээшилж, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтэд бодит ахиц гарсан байна.

Мөн комплайнсын эрсдэлийг үнэлэх, удирдах чадавх сайжирч, байгууллагын дотоод хяналт, соёлд эерэг өөрчлөлт бий болж, салбар хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо идэвхжсэнээр комплайнсын удирдлагын тогтолцоо илүү системтэй, үр дүнд чиглэсэн хэлбэрт шилжих нөхцөл бүрдсэн байна.

¹ Санхүүгийн зохицуулах хороо, Үйл ажиллагааны тайлан 2025 он, 77 дахь тал

Регтек, суптекийг нэвтрүүлэх талаар судлах арга хэмжээний хүрээнд:

Тайланд RegTech, SupTech технологи нэвтрүүлэх талаар судалсан, хэрэгжүүлсэн арга хэмжээ тусгайлан тусгагдаагүй байна. Хорооны үйл ажиллагааны тайланд тусгагдсан арга хэмжээнүүд нь байгууллагын дотоод чадавх, эрх зүйн орчны сайжруулалт, олон нийтэд мэдээлэл түгээх, зах зээлийн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн боловч санхүүгийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагаанд дэвшилтэт технологи (RegTech, SupTech) нэвтрүүлэх, судлах, турших чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тусгагдаагүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд RegTech/SupTech технологийг нэвтрүүлэх арга хэмжээг нийцүүлэн үзэхэд хяналт шалгалт, зөвшөөрөл олголт, эрсдэлийн удирдлага, мөнгө угаахтай тэмцэх, зах зээлийн хяналт зэрэг үндсэн чиг үүргүүдэд шууд уялдаатай бөгөөд эдгээр чиглэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх нь хяналтын үр нөлөө, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна.

Санхүүгийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг олон улсын чиг хандлагад нийцүүлэн сайжруулах хүрээнд RegTech, SupTech технологийг үе шаттай нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд үүнд тайлагналын цахимжилт, өгөгдөлд суурилсан хяналтын систем, эрсдэлийн автомат үнэлгээ, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, инновацийн туршилтын орчин бий болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

1.2. Санхүүгийн үйлчилгээг зохицуулах чиг үүргийн хүрээнд

Хорооны чиг үүргийн хүрээнд дэх холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулсан, шинээр батлагдсны дагуу зохицуулалтын салбарын тоо нэмэгдэж 2025 онд санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн 11 салбар болж хүрээгээ тэлсэн үзүүлэлттэй байна.

2025 онд Хорооны зохицуулалтад хамаарах хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны салбарын нийт хөрөнгийн хэмжээний ДНБ-д (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) эзлэх хувь 26.8 хувьтай тэнцэх хэмжээнд хүрснийг дурдсан байна. Үүнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 15.4 хувь, ББСБ-ын нийт хөрөнгө 10.1 болж өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 2. Зохицуулалттай салбарын нийт хөрөнгийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг/

Он	ДНБ /үйлдвэрлэлийн аргаар тооцсон, тбм.төг/	ДНБ-д эзлэх хувь (%)	Зохицуулалттай албарын нийт хөрөнгийн хэмжээ /тбм.төг/	Өмнөх онтой харьцуулсан өөрчлөлт	
				Пункт	Хувь
2022	53,851.5	23.2%	12,493.5	-	-
2023	70,441.5	24.9%	17,180.3	1.7%	732.8%
2024	80,663.1	26.5%	21,169.6	1.6%	642.6%
2025	89,937.1	26.8%	24,103.1	0.3%	113.2%

Эх сурвалж: https://www.1212.mn/mn/statcate/table-view/Economy,%20environment/National%20Accounts/DT_NSO_0500_001V1.px

Дээрх хүснэгтээс харахад зохицуулалтад хамаарах салбарын нийт хөрөнгийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь 2022 онд 23.2 хувь, 2023 онд 24.9 хувь, 2024 онд 26.5 хувь, 2025 онд 26.8 хувь болж тогтвортой өссөн байна. 2022-2024 онд нийт өсөлт 3.3 пункт байсан бөгөөд хамгийн өндөр өсөлт 2023 онд ажиглагдсан байна. Өмнөх онуудын хурдацтай өсөлт 2025 онд саарч, тогтворжих хандлага ажиглагдаж байна.

Зохицуулалттай салбарын нийт хөрөнгийн хэмжээ жил бүр өссөн нь санхүүгийн зуучлалын цар хүрээ тэлж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 4 жилийн хугацаанд 2 дахин өссөн өсөлттэй байгаа ба ДНБ-д эзлэх хувь мөн нэмэгдэж байгаа нь зохицуулалттай санхүүгийн салбарууд эдийн засгийн өсөлтөөс илүү хурдацтай тэлж байгааг харуулж байна.

Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан талаар мэдээллийг өмнөх 2024 онтой харьцуулан авч үзвэл:

Хороо 2024 онд 4426 зохицуулалттай этгээд, 2504 даатгалын төлөөлөгч бүхий санхүүгийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зохицуулан, хяналт тавьж ажилласан байна. 2024 онд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотойгоор 102 компани хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргаж, нийт 2.8 их наяд төгрөг татан төвлөрүүлж байсан байна.

Харин 2025 онд зохицуулалттай 11 салбарын 5930 этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавьж ажилласан байна. Үүнээс 4787 хуулийн этгээд, иргэд, 1143 нь даатгалын төлөөлөгч байна. Мөн тайлант хугацаанд биржийн зах зээлд 323.6 тэрбум төгрөгийг, биржийн бус зах зээлд 125 үнэт цаас гаргагчийн 1.6 их наяд төгрөг, 63.9 сая ам.долларыг татан төвлөрүүлсэн бөгөөд Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж, биржийн бус зах зээлд давхардсан тоогоор нийт 2.1 их наяд төгрөгийг бондын зах зээлээс татан төвлөрүүлсэн байна.

Хавсралт 1-рт сүүлийн 4 жилээр санхүүгийн зах зээлийн төлөв байдлыг харуулав.

Санхүүгийн зах зээлийн төлөв байдлыг сүүлийн 2 жилийн тоон үзүүлэлтийн өөрчлөлтөөс дүгнэхэд 2024–2025 онд санхүүгийн зах зээл нийт дүнгээр өсөлтийн хандлагаа хадгалсан боловч салбаруудын өсөлт жигд бус, салбарын дотоод бүтэц дэх өөрчлөлт эрчимжсэн байна.

Хөрөнгийн зах зээлд зах зээлийн үнэлгээ, арилжааны идэвх өссөн, оролцогчдын тоо нэмэгдсэн, IPO, бондын санхүүжилт идэвхжсэн зэрэг өөрчлөлтүүд гарсны үр дүнд хөрөнгийн зах зээлийн өсөлт үргэлжилж байгаа боловч хурдац нь саарсан, харин санхүүгийн хэрэгслийн төрөлжилт нэмэгдэж, IPO болон бондын санхүүжилт идэвхжихийн зэрэгцээ хөрөнгө оруулагчдын бүтэц өргөжиж, биржийн болон биржийн бус зах зээлийн уялдаа бэхжсэн нь зах зээлийн дотоод бүтэц, чанарын үзүүлэлтүүдыг сайжруулсан үзүүлэлт болсон байна.

Биржийн бус зах зээл дээр 2021-2025 оны хооронд 5.0 их наяд төгрөг, 181.4 сая ам.долларын бондыг амжилттай татан төвлөрүүлсэн байна². Харин 2025 онд Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж, биржийн бус зах зээлд давхардсан тоогоор нийт 2.1 их наяд төгрөгийг бондын зах зээлээс татан төвлөрүүлсэн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа өмнөх оноос 15.3 хувь буюу 1,363.9 тэрбум төгрөгөөр буурсан байна³.




² Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, 16 дахь тал

³ Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, 18 дахь тал

Даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, хамгаалалтын механизмыг бэхжүүлэх, бүтээгдэхүүний төрөлжилтийг дэмжих чиглэлээр зохицуулалтын орчинг сайжруулсан байна. Үүнд: Даатгалын тухай хууль, холбогдох хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсан, даатгалын багц дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулсан, ипотекийн болон эрүүл мэндийн даатгалын зохицуулалтыг сайжруулсан, Даатгалын компанийн засаглал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг бэхжүүлсэн.⁴

Даатгалын салбарын зохицуулалтын орчин идэвхтэй шинэчлэгдэж, илүү боловсронгуй болж байна. Даатгалын салбарын зохицуулалтын шинэчлэл нь санхүүгийн зах зээлийн эрсдэлийг бууруулах, урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, даатгалын үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх замаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байна. Учир нь даатгалын хураамжийн орлого тогтмол өсөлттэй⁵, даатгалын компаниудын хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 16.4 хувиар өсөж, 771.3 тэрбум төгрөгт хүрсэн, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ өсөхийн зэрэгцээ даатгалын бүтээгдэхүүний төрөл, хамрах хүрээ өргөжсөн нь иргэд, аж ахуйн нэгжийн эрсдэлийг даатгалаар хамгаалах боломж нэмэгдэж, эрсдэлийн хамгаалалт бодитоор сайжирсныг харуулж байна.

Даатгалын үйлчилгээ нь санхүүгийн зах зээл дээр тогтвортой өсөлттэй байгаа боловч зах зээлийн гүнзгийрэлт сул, бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдэж байгаа ч хэрэглээний суурь харьцангуй хязгаарлагдмал байна. Даатгалын салбарт эрх зүйн орчны шинэчлэл, зохицуулалтын арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлсний үр дүнд салбарын үйл ажиллагаанд тавих шаардлага, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоо бэхжиж, даатгалын бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдсэн байна. Даатгалын хураамж, нөхөн төлбөр, хөрөнгийн хэмжээ өссөнөөр санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байгаа боловч ДНБ-д эзлэх хувь бага, зах зээлийн гүнзгийрэлт хангалтгүй, даатгалын хэрэглээ харьцангуй сул хэвээр байна.



Тайлант оны байдлаар даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлд оруулсан хөрөнгө оруулалт 87.5 тэрбум төгрөг хүрч, 5 даатгалын компани олон нийтэд нээлттэй, хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байгааг онцолсон байна. Харин 2024 онд даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлд оруулсан хөрөнгийн хэмжээ 101.7 тэрбум төгрөгт хүрч байжээ. Даатгалын салбар дахь хувьцаа эзэмшигчдийн тоо 2024 онд 25,085 байсан бол 2025 онд 28,261 болж 12.6 хувиар өссөн нь хөрөнгийн зах зээлд оролцогчдын тоо өсөж, олон нийтийн оролцоо нэмэгдсэнийг илэрхийлж байна. Гэвч даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан үзүүлэлттэй байгааг уялдуулан авч үзвэл уг өсөлт нь зах зээл дэх оролцооны цар хүрээг

⁴ Даатгалын багц дүрмийн 1, 2, 9, 10, 12 дугаар хавсралтаар баталсан журмуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 46 дахь тал

⁵ Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, 33 дахь тал

илэрхийлэх боловч хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдсэн гэж үзэхэд хангалттай үндэслэл болохгүй байна.

Харин 2025 онд 5 даатгалын компани олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх болсон нь салбарын оролцооны чанар, бүтэц, ил тод байдлыг сайжруулсан эерэг өөрчлөлт гэж үзэх боломжтой байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулсан, салбарын хэмжээнд мөрдөж ажиллах 4 журмыг шинэчлэн баталсан⁶ /Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам, итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн

этгээд, ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, санхүүгийн харьцааны шаардлагыг шинэчилсэн, итгэлцлийн үйлчилгээ, өрийн бичиг зэрэг эх үүсвэр татах дээд хязгаарыг тогтоосон/, зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд 764 хүсэлтийг шийдвэрлэсэн зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээс харахад эрх зүйн орчныг шинэчлэх, үйл ажиллагаанд тавих шаардлага, санхүүгийн харьцааны шалгуурыг нарийвчлах, эх үүсвэр татах хязгаарлалтыг тодорхой болгох чиглэлээр зохицуулалтын орчинг бэхжүүлж ажилласан байна.

Санхүүгийн зах зээлд үзүүлж байгаа нөлөөллийн хувьд ББСБ-ын салбар нь санхүүгийн зах зээлийн гол хөдөлгөгч сегментүүдийн нэг болж, нийт зээлийн дийлэнх хэсгийг бүрдүүлэн, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Тухайлбал, ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 9,076.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,949.4 тэрбум төгрөг буюу 274 хувиар өссөн, нийт зээл 7,216.3 тэрбум төгрөгт хүрсэн, нийт олгосон зээлийн 87.2 хувь нь хэвийн ангилалд байна. Улсын хэмжээнд 575 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын нийт хөрөнгө ДНБ-ний 10.1 хувийг эзэлж байна. Зардал орлогын харьцааны хувьд ББСБ-ууд 100 төгрөгийн орлого олохын тулд 65.2 төгрөг зарцуулж байгааг тооцоолж гаргасан байна.



Хүснэгт 3. ББСБ-ын олгосон зээлд финтек үйлчилгээний эзлэх хувь /тэрбум төгрөг/

Зээлийн төрөл	Нийт зээл		Зээлдэгчийн тоо	
	Дүн	Хувь	Тоо	Хувь
Финтек	2,285.1	31.7%	2,840,399	90.1%
Уламжлалт	4,931.1	68.3%	313,104	9.9%
Нийт	7,216.2	100.0%	3,153,503	100.0%

ББСБ-ын салбарын нийт олголсон зээлийн 31.7 хувь буюу 2,285.1 тэрбум төгрөгийн зээл финтек үйлчилгээгээр олгогдсон байна. Харин нийт зээлдэгчдийн 90.1 хувь нь финтек⁷ үйлчилгээнд хамрагджээ.

⁶ Санхүүгийн зохицуулах хороо, Үйл ажиллагааны тайлан 2025, 48 дахь тал

⁷ Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, 63 дахь тал

Салбарын хэмжээнд 15,129 зээлдэгчид олгосон ногоон зээлийн үлдэгдэл 152.7 тэрбум төгрөг байгаа нь тус салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.1 хувийг эзэлсэн байна.

ББСБ-ын салбарт зохицуулалттай этгээдийн тоо өссөн, олгосон зээлийн хэмжээ, үйлчилгээний хүрээ өссөн үзүүлэлттэй байгаа боловч эдгээр өсөлтийг дагаад зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүд өсөх хандлагатай байна. Эрсдэлийн үзүүлэлтүүд буюу чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл тус тус өссөн үзүүлэлттэй байгаа нь зээлдэгчийн төлбөрийн чадвар муудах эрсдэлийг үүсгэнэ. Иймд энэ тохиолдолд зээлийн эргэн төлөлтийн эрсдэл нэмэгдэх, орлогын чанар муудах сөрөг талтай. Мөн зээлийн багц хурдтай өсөлттэй буюу өмнөх оноос 25.5 хувиар өссөн байгаа нь зээлийн шалгуур сулрах буюу зээлдэгчийн орлого шалгагдаагүй, зээлийн түүхийг нягтлаагүй, барьцааны үнэлгээ бодитой хийгдээгүй байх эрсдэлийг дагуулдаг. Ингэснээр чанаргүй зээл ирээдүйд нэмэгдэх нөхцлийг үүсгэх юм.

ББСБ-ын салбар нь санхүүгийн зах зээлд хурдтай өсөлттэй, дижитал шилжилт давамгайлсан, финтек төвтэй бүтэц рүү шилжиж байгаа боловч зээлийн чанар, эрсдэлийн төвлөрөл, хэт өсөлтийн эрсдэл зэрэг сорилтууд тулгарах магадлалтай байна.

Хадгаламж зээлий хоршоо салбарт эрх зүйн орчныг шинэчлэх, зохицуулалтын хүрээг өргөжүүлэх, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласнаар, үйлчилгээний зохицуулалтад тавигдах шаардлага, стандартууд сайжирсан гэж үзлээ. Үүнд, Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан байна.


Санхүүгийн зах зээлд үзүүлж байгаа нөлөөллийн хувьд уг салбарын зохицуулалтын шинэчлэл нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн хуримтлал, зээлийн үйлчилгээний сувгийг өргөжүүлэх замаар санхүүгийн зах зээлийн суурийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Үүнд, ХЗХ-ны нийт хөрөнгө 379.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 6.4 хувиар өссөн байна. Нийт зээлийн хэмжээ 290.9 тэрбум төгрөг, нийт хадгаламжийн хэмжээ 279.2 тэрбум төгрөг байна. ХЗХ-ын гишүүдийн тоо тайлант онд 2.5 хувиар өссөн, Улаанбаатар хотод 82 ХЗХ, орон нутагт 94 ХЗХ бүртгэлтэй байна. ХЗХ-ын нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь 0.4 хувь байна.




Хадгаламж, зээлийн хоршооны салбарт эрх зүйн орчны шинэчлэл, зохицуулалтын арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнд салбарын үйл ажиллагаанд тавих шаардлага, хяналтын тогтолцоо сайжирч, нийт хөрөнгө, зээлийн хэмжээ өссөнөөр санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна. Гэвч зах зээлийн хэмжээ харьцангуй бага, өсөлтийн хурдац хэлбэлзэлтэй хэвээр байгаа тул салбарын тогтвортой байдал, үйл ажиллагааны чанарыг цаашид бэхжүүлэх шаардлагатай байна.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарын зохицуулалтын шаардлага, хяналтын механизмыг сайжруулсны үр дүнд эрсдэлийн удирдлага, санхүүгийн сахилга бат дээшилж, зах зээлд оролцогчдын бүтцэд чанарын өөрчлөлт гарч, салбар нь бүтцийн болон чанарын сайжруулалтын үе шатанд шилжиж байна. Өөрөөр хэлбэл зохицуулалтын орчны өөрчлөлтийн нөлөөгөөр үйл ажиллагааны чанар сайжирч, шаардлага хангахгүй гишүүдийн оролцоо буурч, шаардлага хангахгүй ХЗХ-ууд зах зээлээс шахагдан гарч, чанарын сайжруулалт явагдаж байна.

Бусад салбаруудын үзүүлэлтийг зургаар харуулав.



Зураг 8. Үнэт металл, үнэт эдлэл худалдаачид, тэрбум төгрөг



2024–2025 онд санхүүгийн зах зээл нийт дүнгээр өсөлтийн чиг хандлагаа хадгалсан боловч салбаруудын хөгжлийн түвшин, динамик харилцан адилгүй байна. Хөрөнгийн зах зээл тогтвортой өсөлттэй, ББСБ салбар идэвхтэй тэлэлттэй байгаа бол даатгал болон хадгаламж, зээлийн хоршооны салбаруудад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, үйлчилгээний чанар сайжирсан үйл явц давамгайлж байна. Энэ нь санхүүгийн зах зээлийн хөгжил өсөлтөөс тогтворжилт, чанарын хөгжлийн шатанд шилжиж байгааг тодорхойлж байна.

1.3. Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих чиг үүргийн хүрээнд:

Зохицуулалтын салбаруудын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Хөрөнгийн зах зээл: Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчинг сайжруулсан гэж үзсэн байна. Үнэт цаасны зах зээлийн зах зээлийн тухай хуульд 2024 онд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Хорооны зүгээс 2025 онд 4 журам баталж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байна.

Топ 100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж ажилласан байна. Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулснаар, ТОП-100 аж ахуйн нэгж хөрөнгийн зах зээлд үнэт цаас гарган оролцох давуу талууд бүрдсэн гэж үзсэн.

Хорооны зүгээс нийгмийн бондын нэгэн төрөл болох жендер бондын зохицуулалтын орчныг бий болгох зорилгоор “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д ОУСК-тай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж ажилласан байна. Ингэснээр үнэт цаас гаргагчаас дотоодын хөрөнгийн зах зээлд “нийгмийн бонд” болон “Тогтвортой байдлын бонд” гаргах боломж бүрдсэн гэж үзсэн.

Даатгалын салбар: Даатгалын салбарын эрх зүйн орчинг сайжруулсан гэж үзсэн байна. Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай,

Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн барих бэлтгэлийг ханган ажиллаж байгааг тайланд дурдсан байна. Дээрх хуулиуд эцэслэн батлагдаагүй, төслийн шатанд байгаа тул даатгалын салбарын эрх зүйн орчин сайжирсан бус, сайжруулахаар тодорхой ажлуудыг хийж, хэрэгжүүлсэн гэж үзэхээр байна.

Ипотөкийн даатгалын хамгаалалт хангалтгүй байсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Даатгалын багц дүрэм"-д өөрчлөлт оруулж, зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалыг урт хугацааны даатгалд төвлөрүүлэх зохицуулалт нэвтрүүлсэн байна. Энэ зохицуулалт 2025.08.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 5,440 шинэ гэрээ байгуулагдсан байна.

Даатгалын баталгааны зохицуулалт сайжирсан гэж үзсэн байна. Тухайлбал Даатгалын багц дүрмийн 17 дугаар хавсралт, 2, 3, 4, 10 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар дотоодын даатгалын компаниудын баталгааны дээд хэмжээ 4 дахин нэмэгдэж, давхар даатгалын оролцоотойгоор бүх төрлийн баталгаа гаргах боломж бүрдсэн гэж үзсэн байна.

Эрүүл мэндийн мэргэжилтний даатгалын хувьд "Эмнэлгийн мэргэжилтний тухай анхдагч хууль"-ийн төсөлд тусгагдсан эрүүл мэндийн ажилтны хариуцлагын даатгалын зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор холбогдох судалгааг нэр бүхий УИХ-ын гишүүнд хүргүүлж хамтран ажилласан байна. Энэ хууль батлагдсанаар эрүүл мэндийн салбарын хяналт, хариуцлага болон мэргэжилтнүүдийн нийгмийн хамгаалал сайжрах ач холбогдолтойг тайланд дурдсан байна.

Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгалын гэрээ, даатгалын нөхөн төлбөр, мэдээллийн ил тод байдал болон бусад зохицуулалтыг боловсронгуй болгохоор "Даатгалын багц дүрэм"-ийн 1, 2, 9, 10, 12 дугаар хавсралтаар баталсан журмуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Журмын төслүүдэд олон нийтээс санал авах шатанд байна.

Банк бус санхүүгийн байгууллага: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, тандан судалгаа, нөлөөллийн шинжилгээг шинэчлэн боловсруулан УИХ-ын дарга болон ЭЗБХ-ны гишүүдэд танилцуулж ажилласан байна.

Мөн ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөх зарим журам, аргачлалыг шинэчлэн баталсан байна⁸. ББСБ-ын эх үүсвэр татах бүтэц, хэмжээнд дээд хязгаар тогтоож, өрийн санхүүжилт болон гуравдагч этгээдийн хөрөнгөд хэт хамаарах байдлыг бууруулах, санхүүгийн хөшүүргийг хязгаарлах, улмаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлийг бууруулах зэрэг зохицуулалт хийсэн байна.⁹

Хадгаламж, зээлийн хоршоо: Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг боловсруулж ажилласан байна. Хуулийн шинэчилсэн найруулгыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

Үнэт металл, үнэт эдлэл: Үйлчилгээ эрхлэгчдийн эрх зүйн орчинг сайжруулахаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухай бүр орж ажиллан холбогдох саналаа тусгуулж ажилласан байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2025.05.28-ны өдрийн тушаалаар үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний стандартын төслийг хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий Үнэт эдлэлийн стандартчиллын техникийн хорооны бүрэлдэхүүнд орж

⁸ Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, 66 дахь тал

⁹ Санхүүгийн зохицуулах хороо, Үйл ажиллагааны тайлан 2025, 48 дахь тал

ажиллаж, Стандарт, хэмжил зүйн газраас боловсруулсан стандартын төслүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох саналыг тусгуулсан байна¹⁰.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбар: “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж баталсан байна. Үл хөдлөх хөрөнгө борлуулахад ногдуулдаг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу Төсвийн байнгын хорооны тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт зуучлалын байгууллагуудаар дамжин худалдан борлуулагдсан үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс болон хэлбэлзлийн мэдээллийг боловсруулан хүргүүлж “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-аас бүртгэх, үйл ажиллагааг түр зогсоох, бүртгэлээс хасахтай холбоотой хэсгүүд болон эрх олголт, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг зэрэг хэсгүүдийг хасаж, журмыг шинэчлэн боловсруулж Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 74 дүгээр тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан./

Сэндбоксын орчин: Хороо нь технологид суурилсан шинэ, шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг өөрийн хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгож ажилласан гэж тайланд дурдсан байна.

Энэ хүрээнд “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, сэндбоксын орчинд амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулалттай зах зээлд шилжүүлэх үйл явц болон зохицуулалтын орчин бүрдэх хүртэлх хугацааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх талаарх түр зохицуулалт болон сэндбоксын хугацаанд оролцогч үйл ажиллагаагаа түр зогсоох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн тусгай зөвшөөрлийн шаардлагаас зайлсхийх зорилгоор сэндбокс зохицуулалтын орчныг ашиглахыг хязгаарлах нөхцлийг бүрдүүлж ажилласан байна¹¹.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаар: Хороо 10 модулийн хүрээнд 11 дэд ажлын хэсгүүдэд ахлагчаар болон ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, давхардсан тоогоор 169 төр, хувийн хэвшлийн төлөөллүүд тус үнэлгээнд ажиллаж байна.

Хорооны зохицуулалттай салбаруудын мэдээлэх үүрэгтэй этгээдийн Мөнгө угаах болох терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 4.6-д заасны дагуу зохицуулалттай 8 салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдээс хагас жил тутамд эрсдэлийн үнэлгээний асуулга авч, эрсдэлийн түвшинг үнэлж ажилласан байна.

Үндэсний хэмжээний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний ажлын хүрээнд Мөнгөн зээлийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх суурь судалгааг Үндэсний эрсдэлийн үнэлгээний Модуль 6.3 (Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн эмзэг байдлын үнэлгээ)-т нэгтгүүлэх саналыг боловсруулж, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлсэн зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

1.4. Хяналт шалгалтын ажлын үр дүнгийн талаар:

Хяналт шалгалт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд зөрчил илэрсэн 250 этгээдэд 1,645.1 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 799.5 сая төгрөгийн

¹⁰ Санхүүгийн зохицуулах хороо, Үйл ажиллагааны тайлан 2025, 50 дахь тал

¹¹ Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, 137 дахь тал

торгууль төлөгдсөн, 845.6 сая төгрөгийн торгууль төлөгдөөгүй байна. Зөрчил илрүүлсэн хуулийн этгээдийн тоо 16.1 хувиар өссөн бол нийт ногдуулсан торгуулийн дүн 136.1 хувь буюу 948.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх 2024 онд зөрчил илрүүлсэн 91 этгээдэд 671.9 сая төгрөгийн торгууль, өмнөх оны 2 этгээдэд ногдуулсан 25 сая төгрөгийн торгууль буюу нийт 93 этгээдээс 696.9 сая төгрөгийн торгууль төлүүлэхээр болсноос 88 этгээдээс 511.7 төгрөгийн торгуулийг төлүүлсэн байна.

Хүснэгт 4.2024-2025 онд хийсэн хяналт шалгалтын илрүүлэлт /сая төгрөг/

Д/д	Хяналт, шалгалтын үзүүлэлт	2024 он	2025 он	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Шийтгэл оногдуулсан зөрчлийн тоо	120	211	91	75.8
2	Зөрчил гаргасан хуулийн этгээдийн тоо	93	108	15	16.1
3	Зөрчил гаргасан хувь хүний тоо	50	142	92	184.0
4	Нийт торгуулийн мөнгөн дүн /сая төгрөг/	696.9	1645.1	948.2	136.1
5	Төлөгдсөн торгуулийн мөнгөн дүн /сая төгрөг/	511.7	799.5	287.8	56.2
6	Төлөгдөөгүй торгуулийн мөнгөн дүн /сая төгрөг/	185.2	845.6	660.4	356.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Үйл ажиллагааны тайлан 2025

2024–2025 оны системчилсэн үнэлгээний тайлангийн дүгнэлтэд тусгагдсан хяналт шалгалтын үйл ажиллагааг харьцуулан үзэхэд хяналтын арга барилд тодорхой өөрчлөлт гарсан байна.

Тухайлбал, 2024 онд хяналтын үйл ажиллагаа нь зайны хяналт, тайлан мэдээнд суурилсан тоон мониторинг давамгайлж, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг өргөн хүрээнд хамруулсан шинжтэй байсан бол 2025 онд газар дээрх шалгалтын тоо мэдэгдэхүйц нэмэгдэж, хяналтын үйл ажиллагаа нь илүү бодит нөхцөл байдалд тулгуурласан, нарийвчилсан шалгалт, үнэлгээ хийх чиглэлд шилжсэн байна.

Энэхүү өөрчлөлт нь хяналт шалгалтын арга барил нь зөвхөн мэдээлэл, тайланд суурилсан хяналтаас бодит үйл ажиллагаанд суурилсан, эрсдэлийг илүү нарийвчлан тодорхойлох, зөрчил дутагдлыг газар дээр нь илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах боломжийг нэмэгдүүлэх чиглэл рүү шилжсэнийг харуулж байна.

Гэсэн хэдий ч зайны хяналтын тоо хэмжээ буурсан нь зохицуулалттай этгээдийг өргөн хүрээнд хамруулсан тасралтгүй мониторинг хийх ажил тодорхой хэмжээнд буурсан байж болзошгүй тул цаашид зайны болон газар дээрх хяналтын уялдаа, тэнцвэрийг хангах, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иймд хяналт шалгалтын үйл ажиллагаанд өөрчлөлт гарсан гэж үзэх боломжтой бөгөөд цаашид хяналтын үр нөлөөг хэмжих үзүүлэлтийг тодорхой болгох, үр дүнд суурилсан үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

ХОЁР.САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг өгсөн. Энэ хүрээнд СЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны тайлан болон системчилсэн үнэлгээний тайланг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/1148 дугаар албан бичгээр Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн байна.

Системчилсэн үнэлгээний зорилго, хамрах хүрээ нь “Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлоход чиглэсэн бөгөөд дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээний хэлбэрийг сонгож, байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны жилийн тайлан,

санхүүгийн салбарын үзүүлэлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад баримт материалд тулгуурлан үнэлгээг хийсэн байна.

Хорооны 2024, 2025 оны үйл ажиллагааны тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайланг харьцуулан дүн шинжилгээ хийж, гарсан өөрчлөлтийг товч дурдвал:

- 2024, 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95.0-аас дээш хувьтай үнэлэгдсэн байна.
- Санхүүгийн салбарын хамрах хүрээ тэлсэн байна. 2024 онд 4426 зохицуулалттай этгээд, 2025 онд 11 салбарын 5930 зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавьж ажилласан.
- Зах зээлийн өсөлт тогтвортой хадгалагдах чиг хандлага ажиглагдсан байна. 2024 онд санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь 26.5% байсан бол 2025 онд энэ үзүүлэлт 26.8% байна.
- Хорооны үндсэн чиг үүргийн хэрэгжилт тогтвортой байна. 2024-2025 онд үндсэн чиг үүргийн хувьд хяналт шалгалт, зөвшөөрөл бүртгэл, өргөдөл гомдол шийдвэрлэлт, эрх зүйн шинэчлэл гэсэн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлжээ.
- Бодлогын үр дүнгийн талаар хийсэн тайлбар ялгаатай байна. 2024 оны системчилсэн үнэлгээний дүгнэлтэд хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний үр дүнг тухайн арга хэмжээтэй нь уялдуулан, “арга хэмжээ – үр дүн” гэсэн шалтгаан-хамаарлын логикоор тайлбарласан байна. Энэ нь бодлогын хэрэгжилтийн үр дүнг илүү тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлсэн давуу талтай байна. Харин 2025 оны системчилсэн үнэлгээний дүгнэлтэд бодлого, арга хэмжээний үр дүнг дурдсан боловч тухайн үр дүн нь хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээтэй хэрхэн шууд хамааралтай болохыг нотолсон шалтгаан-хамаарлын дүн шинжилгээ хангалтгүй байна.
- Бодлогын хүрээ өргөжсөн буюу оролцогч нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд зохицуулалтын хүрээ уламжлалт санхүүгийн салбараас өргөжин, виртуал хөрөнгө, финтек, сэндбокс орчны зохицуулалт зэрэг шинэ чиглэлүүдийг хамрах болсон нь зохицуулалтын бодлого зөвхөн хяналтын үүргээс гадна инновацыг дэмжих, зах зээлийн хөгжлийг идэвхжүүлэх чиглэлд шилжсэнийг харуулж байна. Ингэснээр инновацыг дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх боломж бүрдүүлсэн хөгжлийн чиг баримжаатай зохицуулалтын түвшинд шилжсэн зэрэг давуу талтай байна.

Үнэлгээний үр дүнгээс дараах дүгнэлтийг гаргав:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал: Хороо 2025 онд 5 зорилго, 4 зорилт, 21 дэд зорилтын хүрээнд нийт 160 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 95.0 хувьтай гэж үнэлэн “бүрэн хангалттай” хэрэгжсэн гэж үзсэн байна. Хэрэгжүүлсэн арга хэмжээний 92.5 хувь нь бүрэн, 6.8 хувь нь хангалттай хэрэгжсэн үзүүлэлттэй байгаа нь төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт өндөр байгааг харуулж байна.

Хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт өндөр түвшинд үнэлэгдэж, төлөвлөсөн арга хэмжээнүүдийн ихэнхийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Гэсэн хэдий ч зарим шалгуур үзүүлэлт нь үр дүн, үр нөлөөг бус үйл ажиллагааны түвшинг хэмжихэд чиглэсэн нь хэрэгжилтийн бодит нөлөөллийг бүрэн тодорхойлоход учир дутагдалтай байна.

2025 оны системчилсэн үнэлгээний дүгнэлтэд гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлт нь хүрсэн түвшинг тодорхойлох боломжгүй, мөн үйл ажиллагааны түвшинд тайлагнал давамгайлж байгааг дурдсан нь үнэлгээний арга зүйн сул талыг өөрийн үнэлгээний хүрээнд илрүүлж, тодорхойлсон гэж үзэх үндэслэл болж байна. Өөрөөр хэлбэл байгууллага өөрөө “үр дүнг тайлагнахдаа үйл ажиллагаа буюу процесс тоочих бус үр дүн, үр нөлөөг тайлагнах шаардлагатай” гэдгийг олж илрүүлсэн буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт /KPI/ зарим арга хэмжээний хувьд оновчгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Байгууллагын үйл ажиллагааны үр дүн: Тайлант хугацаанд санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчныг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, салбарын оролцогчдын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласны үр дүнд:

- Санхүүгийн зах зээл **хурдацтай тэлсэн**, зохицуулалттай этгээдийн тоо 5,930-д хүрч, сүүлийн 5 жилд 45 хувиар өссөн;
- ДНБ-д эзлэх хувь **тогтвортой өсөлттэй буюу** санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ ДНБ-ий 26.8 хувьд хүрсэн;
- Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, арилжааны хэмжээ өссөн;
- Зөвшөөрөл олголт, хяналт шалгалт хийсэн тоо өссөн зэргээс төрийн зохицуулалт идэвхжсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан байна.

Гэвч эдгээр өсөлт нь зөвхөн зохицуулалтын бодлогын үр дүн эсэхийг тодорхойлох шалтгаан-хамаарлын шинжилгээ дутмаг байна.

Зохицуулалтын орчин, эрх зүйн шинэчлэл: Тайлант онд санхүүгийн салбарын эрх зүйн орчныг шинэчлэх чиглэлээр хууль, журмын төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтээс санал авах зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Эдгээр нь салбарын хөгжлийг дэмжих, зохицуулалтын орчныг боловсронгуй болгоход чиглэсэн боловч эрх зүйн өөрчлөлтийн бодит нөлөөлөл хараахан тодорхойгүй байна.

Хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа: Хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрөл олголтын чиг үүргийн хүрээнд:

- 2,628 хүсэлт, баримт бичгийг хянан шийдвэрлэсэн;
- 659 удаагийн газар дээрх шалгалт хийж гүйцэтгэсэн;
- 8,539 тайланд зайны хяналт хийсэн;
- 976 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.

Энэ нь зохицуулалтын үндсэн чиг үүрэг хэрэгжиж байгааг тодорхойлж байгаа боловч үйлчилгээний чанар, хугацаа, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлтээр үнэлсэн дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Үйл ажиллагааны тайланд тусгагдсан мэдээлэл нь хэрэгжилтийн явцыг илэрхийлэх бол системчилсэн үнэлгээний тайлан нь уг мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүн, нөлөө, үр ашгийг үнэлэн дүгнэлт, зөвлөмж гаргагдаараа ялгаатай юм.

Үйл ажиллагааны тайланд “юу хийсэн” талаар, системчилсэн үнэлгээний тайланд “ямар үр дүнд хүрэв” гэдэг талаар тусгах нь оновчтой. Харин системчилсэн үнэлгээний тайланд “хэдэн тогтоол баталсан”, “ямар арга хэмжээ авсан”, “ямар хурал хийсэн” гэх мэт тайлангийн хэлбэрээр бичигдсэн байгаа нь үр дүнгийн үнэлгээг тодорхойлж чадахгүй байна. Жишээ: 21 удаа хуралдаж, 420 асуудлыг хэлэлцэн, 509 шийдвэр гаргасан. Энэ нь тоон үзүүлэлт бол үр дүнг илэрхийлэхгүй зөвхөн үйл ажиллагааны мэдээлэл болж байна.

Үнэлгээний **“үр дүн, үр нөлөө”** хангалтгүй байгаа нь энэхүү тайланг удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах боломжгүй байдал үүсгэх сөрөг талтай. Системчилсэн үнэлгээгээр

- зах зээлийн өөрчлөлт
- бодлогын нөлөө
- үр ашиг зэргийг тодорхойлж гаргахыг голлон анхаарах шаардлагатай.

Тайланд “боломж бүрдүүлсэн”, “дэмжлэг үзүүлсэн” гэх мэт хэт ерөнхий хэллэг ашигласан нь **“яг ямар өөрчлөлт гарсан бэ?”** гэдэг тодорхойлогдохгүй байна. Ингэснээр

“системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-д “үнэлгээ хийх үндсэн зорилгын дагуу хийгдэж байгаа эсэх, эсхүл үндсэн зорилгоосоо хазайсан эсэхийг ажиглах, шаардлагатай бол чиглүүлэх” гэж заасан “чиглүүлэх ажлын хэсэг”-ийн гүйцэтгэх үүрэг хангалтгүй байсныг нотолж байна. Иймд үр дүнгийн шалтгааны шинжилгээ хийгээгүй болохыг тодорхойлж байна.

ГУРАВ.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР

Хорооны 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна. Аудитын дүгнэлтээр төсвийн гүйцэтгэлд нийт 9.3 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 9.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгсөн байна. Мөн нийт 994.2 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн байна. Үүнд:

1.Хөрөнгө оруулалтын дуусаагүй ажлын үлдэгдэл 455.6 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулахдаа дансны өглөг, эргэлтийн бусад хөрөнгийн дансанд бүртгээгүй;

2.Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж нийт 527.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэж, зардлын ангиллыг буруу тайлагнасан;

3.Туслах үйл ажиллагааны орлогын 11.6 сая төгрөгийг бусад орлогоор буруу ангилан тайлагнасан байна.

Дээрх алдаа, зөрчлийг арилгуулахаар төсвийн гүйцэтгэлд 2 зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийн нийцэлд 2 зөвлөмж тус тус өгсөн байна.

Хуулийн этгээдүүдтэй Зохицуулалт үйлчилгээний хөлс, тооцооллыг бүрэн хийж, тооцоо нийлж баталгаажуулж ажиллах тухай 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Харин хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг хуульд заасан цаглаварын дагуу 2026.04.03-ны өдрийн 1/1220 тоот албан бичгээр УАГ-т хүргүүлсэн, аудитын тайлан, дүгнэлт гарах хугацаа болоогүй гэж тайлагнасан. /2026.04.25-ны дотор ирүүлнэ/

Хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайланд батлагдсан төсвийн зардлыг 2,542.2 сая төгрөг буюу 12.2 хувиар хэмнэсэн, төвлөрүүлэх үйл ажиллагааны орлогыг 669.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн буюу 116.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан талаар дурдсан байна. Улсын төсөвт 38.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 1,429.6 сая төгрөгийн торгуулийн орлого тус тус төвлөрүүлсэн байна. Харин аудитын өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар дурдаагүй байна.

ДӨРӨВ. ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана” гэж заасан. Мөн Улсын Их Хурлын 2006 оны 56 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан.

Хяналтын зөвлөлийн ажиллах журмаар 5 чиг үүргийн хүрээнд ажиллах зохицуулалттай байна.

1.Гомдол хянан шийдвэрлэх

- Хорооны шийдвэртэй холбоотой гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх
- 5 хоногийн дотор хариуцагчаас тайлбар авах
- Хуралдаанаар хэлэлцэж шийдвэр гаргах

2. Аудит, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих

- Аудитын байгууллага сонгох үйл явцад хяналт
- Аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хянах

3. Хуралдааны зохион байгуулалт

- Улиралд дор хаяж 1 удаа хуралдах
 - Хуралдаан протокол, тогтоолтой байх
4. Тайлан, мэдээлэлтэй танилцах
- Хорооны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэх
 - УИХ-д жил бүр тайлангаа хүргүүлэх
5. Бодлогын санал боловсруулах
- Хууль, журам, зохицуулалтыг сайжруулах санал гаргах

Дээрх чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

1. Тайлант онд нийт 12 гомдол хүлээн авч 11 гомдлыг шийдвэрлэсэн, гомдол тус бүр дээр тайлбар авч шийдвэр гаргасан, зарим гомдлын мөрөөр хяналт шалгалт хийсэн талаар тайланд тусгасан. Иймд журмын 4-р бүлэгт заасан үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

2. Нийт 21 удаа хуралдаж, Хорооны үйл ажиллагаа, зохицуулалттай салбарууд болон мэрэгжлийн холбоодтой зөвлөлдөх уулзалтыг долоо хоногийн Пүрэв гариг бүрт тогтмол зохион байгуулж, үйл ажиллагааны онцлог, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл солилцон, тулгамдаж буй асуудлуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөлдөн ажилласан байна. Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч биечлэн уулзаж, гаргасан гомдлыг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-ийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай холбоотой 7 албан бичиг, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 11 гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар тайлагнасан. Журмын 5.3-т заасныг хэрэгжүүлж ажилласан буюу улиралд 1 удаа хуралдсан байх, жилд 4 удаа хуралдсан байх үүргээ давуулан биелүүлсэн байна.

3. Хорооны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. 2025 онд хорооны гаргасан 456 шийдвэр, 42 бодлого, 414 зөвшөөрлийг хянаж, ББСБ, зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж хяналт тавьсан байна.

4. Бодлогын санал, зөвлөмж гаргаж ажилласан байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам"-ын холбогдох хэсгийг хууль тогтоомжид нийцүүлэн, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар зохицуулалтыг тусган өөрчлөлт оруулах талаар Хороонд тогтоолоор үүрэгжүүлэн ажилласан байна.

5. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн шинэчлэн боловсруулах талаар Зөвлөлийн 2025 оны 02 дугаартай тогтоолыг гарган Хороонд хүргүүлж ажилласан байна. Дүрэм зөрчдөг, хариуцлагагүй жолооч буюу эрсдэл өндөртэй жолоочийн даатгалын төлөх хувь өндөр, хууль тогтоомж, дүрэм журмыг баримталдаг, осол гаргаж байгаагүй, эрсдэл бага жолоочийн төлөх төлбөрийг бага байх зарчмыг баримталж даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр тогтоох талаар Хороонд чиглэл хүргүүлж ажилласан байна.

6. Ипотекийн зээлийн үйлчилгээ авах иргэд даатгалын үйлчилгээнд заавал хамрагдах бус, сайн дурын үндсэн дээр сонголтоо хийх эрх зүйн баталгааг хангах хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 300 дугаартай тогтоолыг шинэчлэн батлуулсан байна. Уг зохицуулалт нь иргэдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн шударга, ил тод байдлыг хангах бодлогын шийдвэр болсон гэж дүгнэжээ.

7. ОТС зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийж, арилжаалагдаж буй үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн ил тод байдал, мэдээллийн хүртээмж, хөрөнгө оруулагчийг хамгаалах механизмыг сайжруулах санал, зохицуулалтын өөрчлөлтийн төслийг боловсруулах, ББСБ-уудын санхүүгийн эрсдэл, хөшүүрэг, хөрөнгө татан төвлөрүүлэлтийн бүтцийг тодорхой болгож, иж бүрэн дүн шинжилгээ хийх, шаардлагатай бол тайлагнал, хяналт, эрсдэлийн удирдлагын шалгуурыг чангатгах, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн ХК-ууд ХХК болж хэлбэрээ өөрчлөхтэй холбоотой эрх зүйн орчныг нарийвчлан судалж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах тусгай шаардлага, хязгаарлалт, шалгуурыг тодорхой болгох, хувьцаат компани хаалттай хэлбэрт шилжих тохиолдолд заавал мөрдөх ил тод, шударга үнэлгээ, худалдан авах санал, хяналтын журмыг боловсронгуй болгох санал

боловсруулах, эдгээр асуудлуудтай холбоотой дүрэм, журам, зааврыг нэг мөр, ойлгомжтой болгох, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах талаар Санхүүгийн зохицуулах хороонд чиглэл хүргүүлж ажилласан зэргээс Хяналтын зөвлөл 2025 онд хууль, журамд өөрчлөлт оруулах санал гаргаж, зах зээлийн эрсдэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар санал боловсруулж ажилласан байна.

8. Мөн сургалт форум, хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан байна. Зөвлөлөөс санаачлан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Нийслэлийн цагдаагийн газартай хамтран хөрөнгийн зах зээл, санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх болон хүрээлэн буй орчны төлөвлөлтөөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилготой “Санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын санхүүгийн төвүүдтэй холбох, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой “Mongolia’s Capital Market Connectivity 2025” арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд холбох боломжийн талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч, Нийслэлийн бодлогын судалгааны хүрээлэнгийн захирал болон МУИС, ШУТИС, СЭЗИС, МУБИС-ийн эрдэмтэн, докторуудтай нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагаанд туссан Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт, түүнийг хэрхэн шийдвэрлэх, цаашид нийслэлийн хөрөнгө оруулалтын бодлогыг хөрөнгийн зах зээлтэй хэрхэн холбох, түүнээс иргэд хэрхэн үр өгөөж хүртэх, бонд болон үнэт цаасны зах зээлд хэрхэн оролцох боломжийг харилцан зөвлөлдсөн ач холбогдолтой байсан байна.

9. Хяналтын зөвлөл аудитын байгууллагыг сонгоход оролцсон эсэх, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан эсэх талаар тайланд дурдсан баримт нотолгоо байхгүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөл нь 2025 онд “Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-аар тогтоосон үндсэн чиг үүргийн хүрээнд гомдол хянан шийдвэрлэх, хуралдаан зохион байгуулах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын санал боловсруулах чиглэлээр идэвхтэй ажиллаж, үйл ажиллагааны үндсэн шаардлагыг хангаж хэрэгжүүлсэн байна.

Гэвч аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд тавих хяналт, шийдвэрийн биелэлтийн үр нөлөөг үнэлэх, журмын хугацааны мөрдөлтийг тайлагнах хэсэг хангалтгүй туссан нь үйл ажиллагааны нийцэл, үр нөлөөг бүрэн үнэлэхэд хүндрэл учруулж байна.

Иймд Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа нь журмын шаардлагад нийтлэг байдлаар нийцсэн боловч зарим чиг үүргийн хэрэгжилт, тайлагналын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

ДОЛОО ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны тайланд дүн шинжилгээ хийлээ.

Дүн шинжилгээг хийхдээ Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн ситемчилсэн үнэлгээний тайлан, Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн хүрээнд гүйцэтгэж, дараах дүгнэлт, саналыг хүргүүлж байна. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт өндөр үнэлэгдэж, санхүүгийн зах зээлийн өсөлт, тэлэлтэд эерэг үр дүн гарсан боловч зарим үзүүлэлтүүдийн гүйцэтгэл хангалтгүй хэвээр байна.

1. Гүйцэтгэлийн хэрэгжилт өндөр түвшинд үнэлэгдсэн боловч үнэлгээ нь үйл ажиллагаанд төвлөрч, үр дүн, үр нөлөөг бүрэн тусгаагүйгээс бодит үр дүнг хангалттай илэрхийлж чадаагүй байна.

2. Үр дүн, үр нөлөөг хэмжих үзүүлэлтийн тогтолцоо сул байна. Гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлт нь үр дүнг илэрхийлэх боломжгүй, тоон болон чанарын хэмжилт хангалтгүй, суурь болон зорилтот түвшин тодорхойгүй байгаа нь бодит нөлөөллийг үнэлэх боломжийг хязгаарласан байна.

3. Санхүүгийн салбарын өсөлт, тэлэлт ажиглагдаж байгаа боловч бодлогын нөлөөллийн дүн шинжилгээ хангалтгүй байна. Зохицуулалттай этгээдийн тоо, зах зээлийн хэмжээ, ДНБ-д эзлэх хувь өссөн зэрэг эерэг үзүүлэлт ажиглагдсан боловч эдгээр өөрчлөлт нь зохицуулалтын бодлогын шууд үр дүн эсэхийг нотолсон дүн шинжилгээ хангалтгүй байна.

4. Эрх зүйн орчны шинэчлэл, зохицуулалтын арга хэмжээ хэрэгжсэн боловч үр ашиг, хэрэгжилтийн нөлөөллийг үнэлээгүй байна. Хууль, журам боловсруулж, шинэчлэн батлуулах чиглэлээр тодорхой ахиц гарсан хэдий ч эдгээр өөрчлөлтийн зах зээлд үзүүлсэн бодит үр нөлөөг хэмжиж, үнэлсэн дүн шинжилгээ хийгдээгүй байна.

5. Хяналт шалгалт, зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагаа идэвхтэй хэрэгжсэн боловч үйлчилгээний чанарын үнэлгээ хангалтгүй байна. Хяналт шалгалт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, зөвшөөрөл олголтын үйл ажиллагаа тоон үзүүлэлтээр бүрэн тусгагдсан боловч хугацаа, чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтээр үнэлээгүй байна.

6. Системчилсэн үнэлгээний тайланд тухайн жилийн үйл ажиллагааны тайланд дурдсан тоо баримт, үйл явц зэргийг давтан тайлагнасан байна. Хорооны үйл ажиллагааны 2021, 2024, 2025 оны тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайлангуудад харьцуулсан шинжилгээ хийхэд, Хороо тухайн жилүүдэд дотоодын буюу өөрийн байгууллагыг үнэлэх хэлбэрийг сонгож зохион байгуулж ирсэн байна. Үнэлгээнд тухайн жилийн үйл ажиллагааны тайланд дурдсан тоо баримт, үйл явц зэргийг давтан тайлагнасан байна. Иймд цаашид жил бүр дотоод үнэлгээг зохион байгуулах бус, тодорхой давтамжтайгаар хөндлөнгийн байгууллагаар системчилсэн үнэлгээг хийлгэх, өөрийн дотоод үнэлгээг зохион байгуулах бол ТББХ-ны 2013 оны 05 дугаар журмын 2.5-т заасан төрлүүдээс 2.10-т заасны дагуу бүгдийг, эсхүл заримыг сонгон зохион байгуулах гэсний дагуу зарим онд тодорхой нэг төрлөөр үнэлгээг хийх нь үр дүнтэй.

7. Регтек, суптек технологийг нэвтрүүлэх судалгааг хийж гүйцэтгэхэд одоогийн хяналт, тайлагналын тогтолцооны нөхцөл байдлыг үнэлэх, олон улсын туршлагыг судлах, хэрэгцээг тодорхойлох, туршилтын төсөл хэрэгжүүлэх, дата интеграц болон аналитик шийдлийг үе шаттайгаар нэвтрүүлэх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна!

Иймд тус байгууллагын 2025 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээ нь бүтэц, хамрах хүрээний хувьд аргачлалд заасны дагуу хийгдсэн, ерөнхий чиг хандлага, гүйцэтгэлийн түвшинг тодорхойлсон боловч үр дүнгийн бодит нөлөөллийг бүрэн тусгаж чадаагүй, үр дүн, үр нөлөөг хэмжих, бодлогын нөлөөллийг үнэлэх тогтолцоо сул байгаа тул цаашид үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар иж бүрэн хийлгэж хэвших шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан хэлбэрт шилжүүлэх шаардлагатай байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг үйл ажиллагаанд чиглэсэн хэлбэрээс үр дүн, үр нөлөөнд чиглэсэн үнэлгээний тогтолцоонд шилжүүлэх, шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц болгох шаардлагатай байна.

САНАЛ

1. Гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлох, хэмжих нэгжийг уялдуулах, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц байх, цаашид төлөвлөлтийн алдаа, зөрчлүүдийг давтан гаргахгүй байхад анхаарах шаардлагатай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийг хууль болон холбогдох журамд заасан чиг үүргийн дагуу ажиллуулж, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

3. Системчилсэн үнэлгээг хийхдээ журамд заасан үнэлгээний аргачлалын дагуу бодитой үнэлж ирүүлэхэд анхаарах, хөндлөнгийн байгууллагаар 3 жил тутам 1 удаа үнэлгээг хийлгэх талаар шийдвэрлэх;

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

Санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

Үндсэн үзүүлэлтүүд	2022	2023	2024	2025	Өсөлт/бууралт	
					Дүн	Хувь
Хөрөнгийн зах зээл						
Зохицуулалттай хуулийн этгээдийн тоо	3716	3766	4426	4787	361	8.2
Даатгалын төлөөлөгч	2376	2416	2504	1143	-1361	-54.4
Хөрөнгийн зах зээл	6,890.4	11,650.2	13,022.7	13,879.4	856.7	6.6
Нийт арилжааны дүн	594.9	787.2	1,579.9	1,315.5	(264.4)	(16.7)
Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээ	-	7,541.4	8,894.3	7,530.4	(1,363.9)	(15.3)
Биржийн бус зах зээлийн арилжаа						
Бүртгэгдсэн үнийн дүн	734.6	1,010.6	1,783.6	2,385.1	601.5	33.7
Татан төвлөрүүлсэн үнийн дүн	655.9	829.8	1,670.6	1,589.6	(81.0)	(4.8)
Даатгалын зах зээл						
Нийт хөрөнгө	474.9	551.4	662.8	771.3	108.5	16.4
Нөөц сан	216.9	268.9	329.7	352.1	22.4	6.8
Нөхөн төлбөр	94.2	120.9	160.4	193.7	33.3	20.8
Давхар даатгалын нөхөн төлбөр	8.8	16.2	26.2	3.6	(22.6)	(86.3)
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж	304.8	398.7	510.6	596.0	85.4	16.7
Өөрийн болон хөрөнгийн өгөөж	0.1	0.1	0.1	0.2	0.1	100.0
Банк бус санхүүгийн байгууллагын салбар						
Нийт хөрөнгө	3,527.0	4,672.2	7,127.3	9,076.7	1,949.4	27.4
Нийт зээл	2,722.6	3,675.9	5,750.4	7,216.3	1,465.9	25.5
Хэвийн	2,409.1	3,297.4	5,223.0	6,292.1	1,069.0	20.5
Хугацаа хэтэрсэн	106.5	119.4	176.4	318.6	142.2	80.6
Чанаргүй	207.0	259.1	351.0	605.6	254.6	72.5
Нийт орлого	867.9	1,163.2	1,828.2	2,718.0	889.8	48.7
Нийт зарлага	554.9	731.9	1,130.3	1,771.0	640.7	56.7
Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч						
Нийт хөрөнгө	-	100.8	959.2	1421.1	461.9	48.2
Нийт зээл	-	602.9	643.1	840.6	197.5	30.7
Хадгаламж зээлийн хоршоо						
Нийт хөрөнгө	267.7	306.5	356.8	379.8	23	6.4
Нийт зээл	210.2	209.1	258.7	290.9	32.2	12.4
Нийт хадгаламж	187.5	215.2	248.6	279.2	30.6	12.3
Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал						
Үл хөдлөх хөрөнгийн худалдаа	1,705.3	2,287.5	2,850.1	3,325.4	475.3	16.7
Үл хөдлөх хөрөнгийн түрээс	102.1	178.1	234.9	301.3	66.4	28.3
Нийт орлого	86.3	105.7	193.2	188.8	(4.4)	(2.3)
Нийт зарлага	80.4	94.9	183.6	183.0	(0.6)	(0.3)

Цэвэр ашиг	5.9	10.8	9.6	5.8	(3.8)	(39.6)
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид						
Нийт орлого	72.3	63.8	73.9	90.4	16.5	22.3
Нийт зарлага	58.2	51.7	61.4	76.3	14.9	24.3
Цэвэр ашиг	14.1	12.1	12.5	14.1	1.6	12.8
Үнэт металл худалдан авалт	700.1	433.8	323.3	615.2	291.9	90.3
Худалдан авсан үнэт металлын хэмжээ /тонн/	8.68	3.2	1.6	2.1	0.5	31.3
Үнэт металл борлуулалт	670.8	461.1	324.6	636.6	312	96.1
Худалдан борлуулсан үнэт металлын хэмжээ /тонн/	8.39	3.3	1.4	1.7	0.3	21.4
Үнэт эдлэл худалдан авалт	-	20.8	29.6	57.9	28.3	95.6
Үнэт эдлэл борлуулалт	14.7	33.4	48.6	80.1	31.5	64.8
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч						
Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	326.1	241.9	258.3	250	-8.3	-3.2
Сэндбоксын зохицуулалтын орчин						
Сэндбоксын орчинд туршигдаж байгаа компани	4	6	6	4	-2	-33.3
Сэндбоксын орчноос гарсан компани	1	1	-	2	2	-

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн салбарын тойм 2025, Үйл ажиллагааны тайлан 2025



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026 он

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн үндэслэл

Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний статистикийн хороо /цаашид “ҮСХ” гэх/ 2025 оны үйл ажиллагааны тайлангаа 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/255 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан”-д дүн шинжилгээ хийж танилцуулж байна.

Дүн шинжилгээг Статистикийн тухай хууль, Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, ҮСХ-ны 2025 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан, Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан болон Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан (2025 он)-д тус тус үндэслэн хийсэн болно.

НЭГ.ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ


ҮСХ нь Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангах, боловсронгуй болгох, албан ёсны статистик мэдээллийг эрхлэн гаргах, тооцоо, судалгаа, шинжилгээ хийх, олон нийтэд түгээх, статистикийн мэдээллийн чанарыг дээшлүүлэх, салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дээшлүүлэх хүний нөөц, санхүү, технологийг үр ашигтай удирдах хүрээнд ерөнхий 4, үндсэн 9, дэд 39 чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.¹

Албан ёсны статистикийн үйл ажиллагаа, арга зүйн шинэчлэлийн хүрээнд

Статистикийн тухай хуульд заасны дагуу ҮСХ нь албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг анхан шатны бүртгэл, захиргааны мэдээлэл, тооллого, түүвэр судалгаанд тулгуурлан нэгтгэн боловсруулж, улсын хэмжээнд мөрдүүлэх 85 аргачлал, 14 ангиллыг батлан мөрдөж байна. Мөн статистикийн мэдээллийн нэгдсэн санд 6 бүлгийн 859 үзүүлэлтийг тогтмол нийтэлж, 2025 онд бүсчилсэн хөгжлийн 216 үзүүлэлтийг шинээр нэмэгдүүлж, мэдээллийн хамрах хүрээг өргөжүүлсэн байна.

Түүнчлэн 2025 онд нийт 21 нэр төрлийн арга зүйн баримт бичгийг (аргачлал, ангилал, тооллого, судалгааны үзэл баримтлал, гарын авлага) шинээр болон шинэчлэн боловсруулж баталсан нь статистикийн арга зүйг олон улсын стандарттай нийцүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулахад чиглэсэн тодорхой ахиц юм.

Зураг 1.2023-2025 онд шинээр болон шинэчлэн баталсан аргачлал, гарын авлага



¹ Статистикийн салбарын 2026-2030 оны стратеги төлөвлөгөө, мандатын шинжилгээ, ҮСХ, 2025 он.

Гөвч зураг 1-ээс харахад шинээр болон шинэчлэн баталсан арга аргачлалын тоо өмнөх жилүүдээс буурсан байгаа бөгөөд улсын хэмжээнд мөрдөж буй 85 аргачлал, 14 ангиллын хэдэн хувь нь олон улсын арга аргачлалд бүрэн нийцсэн, цаашид нийцүүлэх шаардлагатай хэдэн арга, аргачлал байгаа талаар тайланд тодорхой тусгах шаардлагатай байна.

Албан ёсны статистикийн мэдээллийг бүрдүүлэх хүрээнд аймаг, нийслэлийн статистикийн нэгжүүдээр 47 маягтаар, төрийн 43 байгууллагаас 415 маягтаар мэдээлэл цуглуулж, сарын 53, улирлын 27, жилийн 335 мэдээллийг нэгтгэн боловсруулж, батлагдсан хуваарийн дагуу нийтэлж статистикийн мэдээллийн ил тод, тасралтгүй байдлыг хангаж ажиллажээ.

Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлд ҮСХ-ноос хийх тооллого, судалгааг хугацааны хамт хүснэгт 1-т харуулсны дагуу тодорхой зохицуулсан бөгөөд энэ хүрээнд тайлант онд “Хүн ам, орон сууцны завсрын тооллого”, “Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого” гэсэн 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлж хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Хүснэгт 1. Статистикийн тухай хуульд заасан тооллого, судалгааны давтамж

Д/д	Тооллого, судалгаа	Давтамж
1	хүн ам, орон сууцны ээлжит болон завсрын тооллого	10 жил, 5 жил тутам
2	салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгт	5 жил тутам
3	мал, тэжээвэр амьтдын тооллого	жил тутам
4	малын хагас жилийн тооллого түүвэр судалгааны аргаар	хуульд заасан хугацаа
5	өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа	улирал тутам
6	нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жил тутам
7	хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгаа	улирал тутам
8	аж ахуйн нэгжийн тооллого	5 жил тутам
9	хашаа, худаг, тэжээлийн тооллого	3 жил тутам
10	цаг ашиглалтын түүвэр судалгааг	4 жил тутам улирлаар
11	хөдөө аж ахуйн ээлжит тооллого, завсрын тооллого, судалгаа	10 жил, 5 жил тутам
12	гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа	3 жил тутам
13	судалгаа хөгжүүлэлтийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын судалгаа	3 жил тутам

Зайлшгүй шаардлагаар тооллого, судалгааны хугацааг өөрчлөх, хуульд зааснаас өөр тооллого, судалгаа явуулах асуудлыг Засгийн газар, эсвэл ҮСХ-ны саналыг үндэслэн УИХ шийдвэрлэхээр хуульд заасан бөгөөд энэ хүрээнд 2025 онд тооллого, судалгаа хийгдээгүй байна.

ҮСХ-ны 2025 оны үйл ажиллагааны тайланд тухайн онд хэрэгжүүлсэн ажлууд, үр дүнг дэлгэрэнгүй тусгасан байгаа тул энэхүү дүн шинжилгээгээр давтан дурдахгүйгээр анхаарвал зохих зарим асуудалд дүн шинжилгээ хийлээ.

Үйл ажиллагааны шинэчлэл, цахимжилтын хүрээнд

ҮСХ-ны сүүлийн 2 жилийн үйл ажиллагааны тайлангаас харахад 2024 онд өгөгдлийн засаглал, мэдээллийн сангийн бүтэц, мета өгөгдлийн орчныг бүрдүүлэхэд голчлон анхаарч ажилласан бол 2025 онд эдгээр суурь ажлуудад тулгуурлан хэрэгжилтийн шатанд шилжиж, статистикийн мэдээллийн хамрах хүрээг өргөжүүлэх, өгөгдлийн дэд бүтцийг сайжруулах, дижитал технологийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой ахиц гаргасан байна. Ялангуяа төрийн мэдээллийн сангуудыг ашиглах, бүртгэлд суурилсан тооллогын аргыг нэвтрүүлэх, өгөгдөл боловсруулах үйл ажиллагаанд шинэ технологи ашигласан зэрэг нь статистикийн уламжлалт арга барилд өөрчлөлт оруулах чиглэлд хийсэн бодит алхам болсон байна.

“Үйл ажиллагааны шинэчлэл, цахимжилт” хэсгээс үзэхэд мэдээллийн систем, дэд бүтэц, статистикийн мэдээний систем, статистикийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэхэд тодорхой үр дүнтэй ажлууд хийгдэж, ахиц гарсан бөгөөд тухайлбал, статистикийн мэдээллийн нэгдсэн санг нээлттэй эхийн платформд шилжүүлж, системийн хайлт, мэдээлэл харах хурдыг өмнөх хувилбараас 50 дахин нэмэгдүүлсэн, мөн чатботыг

хөгжүүлсэн зэрэг нь хэрэглэгчид хэрэгцээт мэдээллээ шуурхай олж авахад цахим үйлчилгээний хурд, чанарыг сайжруулахад чиглэсэн байна.

Түүнчлэн статистикийн мэдээ, тооллого, судалгааны үйл ажиллагаанд цахим хяналтын систем, дашбоард, зураглал, хиймэл оюунд суурилсан туршилт зэрэг технологийн шийдлүүдийг ашиглаж эхэлсэн нь өгөгдөл цуглуулах, хянах, боловсруулах үйл ажиллагааг илүү шуурхай, уялдаатай болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Тодруулбал, мал тооллогын мэдээллийн санг салбарын яамны бүртгэлийн сантай уялдуулан шалгах, дроны зураглал, AI аппликейшн туршсан нь технологид суурилсан шинэчлэлийн жишээ гэж үзэж болохоор байна.

Гэсэн хэдий ч дээрх шинэчлэлийг үр дүн талаас нь авч үзвэл үйл ажиллагааны тайланд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан хэдий ч тэдгээрийн үр дүнд статистикийн мэдээллийн чанар, шуурхай, найдвартай байдал болон хэрэглээнд бодитоор хэрхэн өөрчлөлт орсон талаарх хэмжигдэхүйц үзүүлэлт, нотолгоонд суурилсан тайлагнал, мэдээлэл хангалтгүй байгаа нь харагдаж байна. Жишээлбэл, бүртгэлд суурилсан тооллогын аргыг нэвтрүүлснээр зардлыг бууруулах, мэдээлэл цуглуулах давхардлыг арилгах, өгөгдлийн чанарыг сайжруулах ач холбогдолтой хэдий ч уг өөрчлөлтийн үр дүнд зардал хэр хэмжээгээр буурсан, мэдээлэл боловсруулах хугацаанд ямар өөрчлөлт гарсан, алдааны түвшин буурсан эсэх зэрэг өөрчлөлийг тоон үзүүлэлтээр илэрхийлсэн мэдээлэл тайланд тусгаагүйгээс уг шинэчлэлийн үр нөлөөг бодитоор үнэлж, дүгнэх боломжгүй байна.

Иймд цахим шинэчлэл, технологийн нэвтрүүлэлтийг цаашид зөвхөн систем нэвтрүүлсэн, үйл ажиллагааг хялбаршуулсан түвшинд бус, түүний үр ашиг, бүтээмж, хэрэглээ болон зардлын түвшинд үзүүлж буй нөлөөг хэмжих үзүүлэлт, тайлагналтын түвшинд илүү тодорхой болгох шаардлагатай байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс:

НҮБ-аас баталсан “Албан ёсны статистикийн чанарын баталгааны хүрээ” баримт бичигт статистикийн байгууллагыг хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжийг тогтмол судалж, системтэйгээр хянаж, сайжруулах шаардлагатайг онцолсон байдаг. Мөн статистик мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг үнэлж, мэдээлэл олж авахад гарч байгаа аливаа хүндрэл, бэрхшээлийг бууруулж, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, статистикийн мэдээлэлд итгэх итгэлийг дээшлүүлэхэд хэрэглэгчийн санал, хүсэлт чухал ач холбогдолтой. Энэ ч үүднээс ҮСХ нь 2025 болон 2026 онд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.

2025 онд 2,189 хэрэглэгчийг хамруулсан хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар²:

- бизнесийн байгууллагын 40 орчим хувь нь **“мэдээлэл хэт ерөнхий, задаргаа хангалтгүй”**;
- Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 60 орчим хувь нь **“нарийвчилсан мэдээлэл олж авахад хүндрэлтэй, хугацаа шаарддаг”**;
- Хэвлэл мэдээлэл, медиа салбарын 40 гаруй хувь нь мэдээлэл олоход **цаг хугацаа их шаарддаг, нарийвчлал дутмаг**;
- Их, дээд сургууль, ЕБС, судалгааны байгууллагууд болон оюутнуудын 40 гаруй хувь нь мөн **мэдээлэл хэт ерөнхий, нарийвчлал хангалтгүй** гэсэн хариултыг өгсөн байна.

Судалгааны үр дүнгээр хэрэглэгчийн бүлэг тус бүрийн 40-60 хувь нь статистикийн мэдээлэл хэт ерөнхий, нарийвчлал, задаргаа, хүртээмж, шуурхай байдал хангалтгүй гэж дүгнэсэн байна. Мөн ҮСХ-ны үйл ажиллагааг сайжруулахын тулд статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв, бодитой тоон мэдээллийг цаг хугацааны хоцрогдолгүй хүргэх, орон нутгийн статистикийн хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах, албан хаагчдыг чадавжуулах чиглэлд илүү анхаарах шаардлагатайг судалгааны үр дүнгээс харж болохоор байна.

² Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, ҮСХ, 2025 он, 19-21 дэх тал.

Харин тайлант онд сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн сайжруулалтын **арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлсэн байдал тодорхойгүй** байна. Иймд жил бүр хийгдэж байгаа хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үндэслэн тулгарч буй асуудлыг шийдвэрлэх болон статистикийн мэдээллийг нарийвчлах чиглэлээр арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал:

Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн тухайд авч үзэхэд эрсдэлийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын хүрээнд тодорхой ахиц гаргаж, эрсдэлийн зөвлөл, орон тооны бус нэгжийг байгуулан ажиллуулж, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ авах үйл явцыг системтэй хэрэгжүүлж байна. Мөн эрсдэлийн мэдээллийн системийг хөгжүүлж, эрсдэлийн бүртгэл, хяналтыг тогтмолжуулах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх чиглэлд тодорхой алхмууд хийгдсэн байна.

Үүний зэрэгцээ эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн үр дүнг авч үзэхэд зарим асуудал ажиглагдаж байна. Тухайлбал, 2025 оны байдлаар ҮСХ, нийслэл болон аймгийн статистикийн газар, хэлтсийн түвшинд нийт 252 эрсдэл тодорхойлогдсоноос 78.1 хувь нь хариу арга хэмжээ шаардлагатай түвшинд үнэлэгдсэн нь байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн түвшин харьцангуй өндөр байгааг харуулж байна. Үүнээс 197 эрсдэлд төлөвлөсөн арга хэмжээнээс 80 нь бүрэн хэрэгжиж, хэрэгжилтийн түвшин 43.0 хувьтай байгаа нь эрсдэлийн хариу арга хэмжээний хэрэгжилтийг цаашид сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Мөн эрсдэлийн удирдлагын тогтолцоо “хөгжиж буй шат” (3 дугаар түвшин)-нд үнэлэгдсэн нь бодлого, журам, бүтэц бүрдсэн боловч эрсдэлийн удирдлагыг байгууллагын стратеги төлөвлөлт, шийдвэр гаргалттай уялдуулан хэрэгжүүлэх, тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд 2025 онд төлөвлөгөөний дагуу олон чиглэлд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, мэдээллийн аюулгүй байдал, дотоод хяналтын тогтолцоо, санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, статистикийн мэдээллийн чанар зэрэг чухал асуудлуудыг хамруулсан байна. Энэ нь дотоод хяналтын үйл ажиллагаа тогтмолжсон, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоо тодорхой түвшинд бүрдсэн байна.

Нөгөө талаас хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил, үл тохирол, сайжруулах шаардлагатай асуудлын тоо харьцангуй өндөр байгаа нь дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилт зарим чиглэлд сул байгааг анхаарч, сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Тухайлбал, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хүрээнд 35 үл тохирол илэрсэн, Тамгын газрын үйл ажиллагаанд “сайжруулах шаардлагатай” дүгнэлт өгөгдсөн, мөн журам, зааврын шинэчлэл, хэрэгжилттэй холбоотой зохицуулалт дутуу зэрэг болно.

Түүнчлэн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь зөрчил илрүүлэх, зөвлөмж өгөх түвшинд төвлөрсөн бөгөөд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, түүний үр нөлөөг хэмжих, дахин давтагдахаас сэргийлэхэд цаашид анхаарах шаардлагатай байна. Өмнөх **аудитын зөвлөмжийн хэрэгжилт 75 хувь** байгаа нь тодорхой ахиц боловч бусад хэрэгжилтийн чанар, үр нөлөөний талаар үнэлгээ хийх нь чухал байна.

Үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийсэн талаар:

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа УИХ-д ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг, чиглэл өгсний дагуу ҮСХ нь 2025 оны үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн байна.

Системчилсэн үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, тавьсан зорилгодоо хүрсэн байдлыг тодорхойлоход чиглэх бөгөөд ҮСХ нь байгууллагын чиг

үүргийн хэрэгжилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хүний нөөцийн хэрэгцээ, санхүү, төсвийн үйл ажиллагаа гэсэн асуудлыг хамруулан гүйцэтгэсэн байна.

“Байгууллагын үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээ хийх” аргачлалд арга хэмжээний үр өгөөжийг тодорхойлох, зорилгод хүрсэн байдал, зарцуулсан зардал-гарсан үр дүнгийн харьцаа, үр ашгийг тодорхойлох, төлөвлөсөн зорилгод хүргэж болохуйц сонголтуудыг тодорхойлохоор заасан.

Гэвч чиг үүргийн үнэлгээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, санхүү, төсвийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн үнэлгээ нь хэрэгжүүлсэн ажлуудыг нэгтгэн дүгнэсэн шинжтэй, үйл ажиллагааны тайлангаас төдийлөн ялгаагүй байгаа нь системчилсэн үнэлгээ хийх аргачлалын дагуу хийгдээгүй гэж дүгнэж болохоор байна.

Харин хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээгээр байгууллагын төв болон орон нутгийн нэгжүүдийн ачаалал, цалин хөлс, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлд зарим асуудал эрсдэл тулгарч байгааг гаргасан байна. Үнэлгээгээр аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн статусыг УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын жишигт нийцүүлэн өөрчлөх, ажлын хүрээ, ачаалалд нь дүйцсэн цалин олгох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг судлан шийдвэрлэх асуудлыг гаргаж тавьсан нь хүний нөөцийн өнөөгийн тогтолцоо байгууллагын чиг үүргийн өсөлт, ажлын ачаалалтай бүрэн нийцэхгүй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хүний нөөцийн үнэлгээ зөвхөн орон тооны тоо хэмжээнд бус, бүтэц, статус, урамшуулал, тогтвортой байдлын асуудлыг хөндсөн нь системчилсэн үнэлгээний бодит ач холбогдлыг гаргасан байна.

Цаашид үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээ хийхдээ дотоодын үнэлгээний багаар бус хөндлөнгийн үнэлгээний хэлбэрийг сонгож хийлгэвэл хараат бус бие даасан, илүү бодитой үнэлгээний үр дүн гарч, байгууллагын хүрээнд тулгамдаж буй асуудал, алдаа дутагдлыг олж харах давуу талтайг зөвлөж байна.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн талаар:

ҮСХ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 5 зорилтын хүрээнд 22 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу дүгнэхэд төлөвлөгөөний биелэлт 92.7 хувьтай гэж дүгнэгдсэн байна.

Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын статистикийн мэдээний маягт, нөхөх заавар, аргачлал, Барилга байгууламжийн өртгийн мэдээ, Монголбанк, арилжааны банкны орлого, зарлагын мэдээний маягт, нөхөх зааврыг шинэчлэн боловсруулж баталсан бөгөөд ДНБ-ийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох шинэ аргачлалыг нэвтрүүлсэн байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд уялдаа, хамралт сайжирч, мэдээллийн нэгдсэн санг баяжуулах, тооцоолол, шинжилгээний нарийвчлалыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн нь бодлого боловсруулах, шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах чадавхыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болсон байна.

Харин гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй буюу 70-85 хувийн биелэлттэй дараах 4 арга хэмжээ байна. Үүнд:

- “Албан хаагчдын албан тушаалын чиг үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьцуулан дүгнэж ажлын ачааллыг тодорхойлох, KPI тооцоолох боломжит суурь үзүүлэлтийг танилцуулах” арга хэмжээний хүрээнд албан хаагчдын чиг үүргийн давхардал, ажлын ачааллыг тодорхойлсон боловч KPI тооцоолох боломжит суурь үзүүлэлтийг боловсруулаагүй, албан тушаал бүрд тохирсон KPI үзүүлэлтийг тодорхойлох зорилтот түвшинд хүрээгүй;
- 2025 онд 2 тооллого, 8 түүвэр судалгааг зохион байгуулж, үр дүнг тархаах, 1 тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөснөөс 2 судалгааг зохион байгуулсан боловч үр дүнг тархаагаагүй;

- “2 тооллого, 7 судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 3 салбарын мэдээний маягт, нөхөх заавар, 1 аргачлалыг олон улсын стандартын дагуу шинэчлэн сайжруулах, шинээр боловсруулж, батлах”-аар төлөвлөснөөс аж ахуйн нэгжийн тооллогын үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар болон соёлын статистикийн аргачлалыг эцэслэн батлуулаагүй;
- Аж үйлдвэр, барилгын салбарын мэдээ болон мал тооллогын мэдээлэлд түүвэр судалгааны аргыг турших, олон улсын туршлагад тулгуурлан түүвэрлэлт хийж үр дүнг бодит мэдээтэй харьцуулан салбар, дэд салбарын түвшинд хэрэгжүүлэх боломжийг үнэлэхээр төлөвлөсөн боловч аж үйлдвэр, барилгын салбарын мэдээнд түүврийн аргыг ашигласан бодит туршилт хийгдээгүй байна.

ҮСХ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нийт дүнгээр “бүрэн хангалттай” гэж үнэлэгдсэн хэдий ч зарим арга хэмжээ 85-95 хувийн хэрэгжилттэй буюу зорилтот түвшинд бүрэн хүрээгүй байна. Эдгээр нь голчлон хуулийн төсөл батлагдаагүй, боловсруулсан систем, аргачлалын үр дүнг бүрэн нэгтгэж тайлагнаагүй (сургалтын системийн үнэлгээ), хөгжүүлсэн программ хангамжийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж дуусаагүй зэрэгтэй холбоотой байна. Иймд цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

ҮСХ-ны 2025 оны үйл ажиллагааны тайланд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан, мэдээ эцэслэж гараагүйтэй холбоотойгоор холбогдох мэдээлэл тусгагдаагүй байна.

ХОЁР.БОДЛОГЫН БАРИМТ, БИЧИГ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1.ҮСХ-нд хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон УИХ-ын шийдвэрийн биелэлтийн талаар:

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлэхээр заасан. Үүний дагуу ҮСХ-ноос 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/155 дугаар албан бичгээр хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон УИХ-ын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар ҮСХ-д хамаарах 1 хуулийн 1 хэсэг, үүрэг, чиглэл болгосон УИХ-ын 3 тогтоолын 8 заалт, Байнгын хорооны 2 тогтоолын 11 заалт бүртгэлтэй байна.

УИХ-аар 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Малчны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.11-д “Малчны хөгжлийн индексийг тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Үндэсний статистикийн хороотой хамтран баталж, хяналт тавих”-аар заасан байна. Энэ хүрээнд ҮСХ-ноос Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны боловсруулсан төсөлд санал өгсөн бөгөөд тус эрх олгосон заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2025 оны 61 дүгээр тогтоолыг баталсан.

Тус тогтоолоор Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хуульд нийцээгүй болон бүртгэлгүй актуудыг цэгцлэх, шаардлагагүй, зөрчилтэй зохицуулалтыг хүчингүй болгох, шинэчлэн батлах, хүний эрх, авлигын эрсдэлийг арилгах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах, мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, нэгдсэн санд тогтмол байршуулан тайлагнах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар болон УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад үүрэг болгосон байна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд ҮСХ-ны даргын шийдвэрээр баталсан 10, салбарын сайдтай хамтран баталсан 4 шийдвэр бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар хэм хэмжээний акт батлаагүйгээс

гадна хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна.

Харин Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу жил бүр хүн амын амьжиргааны доод түвшинг тогтоосон шийдвэрийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/11 дүгээр тушаалыг ХЗДХЯ-нд хүсэлт илгээж, хяналтын шатанд байна.

Тогтоолын 3-т заасан “Хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох салбарын хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}, 27^{1.2} дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийн судалгаа, саналыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан ирүүлэх” хүрээнд Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, ҮСХ-ны даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны 01/921 тоот албан бичгээр хууль санаачлагчид хүргүүлж, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн d.parliament.mn цахим хуудсанд байршуулж, хуулийн төсөлд олон нийтээс санал авч эхэлсэн байна.

Харин тогтоолын 4 дэх заалтад тусгагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, үнэлгээг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах үүрэг, чиглэл хэрэгжээгүй байна. өөрөөр хэлбэл хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна. Иймд тус тогтоолын хэрэгжилт **хэсэгчлэн хангагдсан** гэж дүгнэхээр байна.

Мөн УИХ-ын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 3-т “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтарч ажиллах”, мөн Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай УИХ-ын 2025 оны 78 дугаар тогтоолын 4-т Монгол Улсын Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг тус тус УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үүрэг болгосон.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрээнд ҮСХ хариуцахаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн 2024-2025 оны гүйцэтгэлийн мэдээллийг гарган Засгийн газарт хүргүүлж хэрэгжилтийг хангасан байна.

Харин процессын дахин инженерчлэл хийх ажлын хүрээнд төрийн нэгдсэн мэдээллийн санд байгууллагуудын мэдээллийг нэгтгэх, мета мэдээллийг шинэчлэхээр Засгийн газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай, мөн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн үр ашигтай байдлыг хангах, орон нутгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, ЗГХЭГ-тай үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд одоогоор тодорхой үр дүн гараагүй байна.

ЭЗБХ-ны 2018 оны “Чиглэл өгөх тухай” 08 дугаар тогтоолоор ҮСХ-ны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, төсөв, санхүүжилтийн хүрэлцээг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах чиглэлээр идэвхтэй дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар болон ҮСХ-нд өгсөн 9 заалт бүхий үүрэг, чиглэлийн хэрэгжилт 86.7 хувь байна.

2.2. “Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүнгийн талаар:

ҮСХ-ны даргын 2021 оны А/114 дүгээр тушаалаар “Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөө”-г баталж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний нөөцийн хөгжлийг хангах, дэд бүтцийг сайжруулах, статистикийн мэдээлэл эрхлэн гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох гэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд нийт 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дараах үр дүнд хүрэхийг зорилт болгосон:

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Албан ёсны статистикийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин боловсронгуй болж, арга зүйн бие даасан хараат бус байдал бэхжих, байгууллагуудын чиг үүрэг тодорхой, уялдаа сайжирч, статистикийн мэдээлэл боловсруулах, ашиглах үйл ажиллагааны нэгдмэл зохицуулалт бүрдэх.

Хүний нөөцийн хөгжлийг хангах

Статистикийн байгууллагын албан хаагчдын системтэйгээр сургаж, мэдлэг, ур чадвар сайжирч, мэргэжлийн тогтвортой, чадавхтай хүний нөөц бүрдэн, статистикийн мэдээллийн чанар дээшлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдаж, сэтгэл ханамж, бүтээмж нэмэгдэх.

Дэд бүтцийг сайжруулах

Нэгдсэн стандарт, аргачлалыг нэвтрүүлэх, төрийн мэдээллийн нэгдсэн санг байгуулах, уялдуулах, мэдээллийн зөрүүтэй байдал арилах, төрийн болон бусад эх үүсвэрийн мэдээллийг холбож ашиглах нэгдсэн тогтолцоо бүрдэх.

Статистикийн мэдээлэл үйлдвэрлэл, тархаалтыг боловсронгуй болгох

Статистикийн мэдээллийн чанар, хүртээмж, шуурхай байдал нэмэгдэж, хэрэглэгчдэд ээлтэй, олон эх үүсвэрт суурилсан, бодлого шийдвэр гаргалтыг дэмжихүйц мэдээлэл, шинжилгээ тогтмол хүргэх боломж бүрдэх.

“Статистикийн салбарын 2021–2025 оны стратеги төлөвлөгөө” нийт дүнгээр **86.2 хувь** буюу **“үр дүнтэй”** хэрэгжсэн гэж дүгнэгдсэн боловч зорилтын түвшинд авч үзвэл 2 зорилт төлөвлөсөн үр дүнд хүрсэн бол 2 зорилт бүрэн хүрээгүй, 23 арга хэмжээнээс 17 нь үр дүн гарсан, 6 нь үр дүн гараагүй байна.

Хууль, эрх зүйн орчныг шинэчлэх хүрээнд зарим дүрэм, журам, арга зүйн баримт бичгийн шинэчлэл хийгдсэн, хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагчид хүргүүлж, олон нийтээс санал авч байгаа боловч эрх зүйн шинэчлэл хийгдээгүй хэвээр байна.

Хүний нөөцийн хөгжлийн хүрээнд сургалт, чадавхжуулах тодорхой ажлууд хэрэгжсэн боловч тогтвортой үр дүнд хүрээгүйгээс гадна зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн алдаатай байдал нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Дэд бүтцийн чиглэлд өгөгдлийн сан, мэдээллийн системийг хөгжүүлэх суурь ажлууд хийгдсэн боловч нэгдсэн систем, техникийн хүчин чадал бүрэн хангагдаагүй, санхүүжилтийн хязгаарлалттай холбоотойгоор зорилт бүрэн биелээгүй байна. Мөн зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд санхүүжилт нөлөөлсөн бөгөөд үр дүнгүй хэрэгжсэн 6 арга хэмжээнээс 3 нь санхүүжилтээс шалтгаалсан байна. Ялангуяа дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нөөц дата төв байгуулах, зарим судалгааг зохион байгуулах зэрэг үндсэн арга хэмжээнүүд санхүүжилтийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй байна.

Харин статистикийн мэдээлэл үйлдвэрлэл, тархаалтын чиглэлд хамгийн их ахиц гарч, мэдээллийн хамрах хүрээ, хэрэглэгчийн хүртээмж, технологийн хэрэглээ нэмэгдсэн байна. Түүнчлэн стратеги төлөвлөгөөнд туссан статистикийн хэрэглэгчид тэр дундаа бизнес эрхлэгчдийн мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай тоо мэдээллийг бий болгох хүрээнд хэрэглэгчдийн эрэлт ихтэй салбарыг тодорхойлсон боловч хэрэгцээтэй байгаа мэдээлэл, үзүүлэлтийг нарийвчлан гаргах ажил хийгдээгүй зэргээр төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь төлөвлөлтийн шатанд гарсан алдаа бөгөөд **нийт 23 арга хэмжээнээс 13-т нь төлөвлөлтийн, 6-д нь хэрэгжилтийн алдаа** илэрсэн талаар хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан байна. Төлөвлөлтийн алдаа нь зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон, зорилт, арга хэмжээний уялдаа хангагдаагүй, бодит нөөц боломжид нийцээгүй төлөвлөлт хийсэнтэй холбоотой байна.

Иймд стратеги төлөвлөгөө нь үйл ажиллагааны түвшинд тодорхой үр дүн гарч, хэрэгжилт тоон үзүүлэлтээр **өндөр (82.6%) үнэлэгдэж**, ихэнх арга хэмжээ хэрэгжсэн боловч зорилтот үр дүнг бүрэн хангаагүй, үр дүнд суурилсан төлөвлөлт, тайлагналт хангалтгүй байна.

Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн үр дүнг тооцох үзүүлэлт, арга зүйг сайжруулах асуудлаар:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт Үндэсний статистикийн хороонд дараах чиг үүргийг зааж өгсөн. Үүнд:

- 9.7.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

- 9.7.2.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах.

Энэ хүрээнд ҮСХ нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрээнд ҮСХ хариуцахаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн 2024-2025 оны гүйцэтгэлийн мэдээллийг гарган Засгийн газарт хүргүүлсэн нь хуульд заасан чиг үүргийг хангаж ажилласан байна.

Мөн Тогтвортой хөгжлийн зорилгын 251 шалгуур үзүүлэлтээс Монгол Улс 2025 оны байдлаар 162 үзүүлэлтийг тооцох боломжтой болсон нь мэдээллийн бэлэн байдал сайжирч байгааг харуулж байна. Гэвч 76 үзүүлэлтэд мэдээллийн эх үүсвэр бүрдээгүй хэвээр байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн гүйцэтгэлийн тайланг УИХ-аар хэлэлцэх, дүн шинжилгээ хийх явцад зарим зорилт, төсөл, арга хэмжээний суурь түвшин тодорхойгүй, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт оновчгүй, тооцох аргачлал дутмаг, зарим үзүүлэлтийн мэдээлэл гараагүй, хугацаа болоогүй зэрэг шалтгаанаар зарим бодлогын зорилго, зорилт, арга хэмжээний биелэлт, үр дүнг бүрэн тооцож чадахгүй байх тохиолдол гардаг.

Эдгээр нөхцөл байдлаас үзэхэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний хүрсэн үр дүнг бодитоор үнэлэхэд статистикийн тоон үзүүлэлт, чанар, хүртээмж, цаг хугацаандаа гарах зэргээс гадна шалгуур үзүүлэлтийн оновчтой байдал, арга зүйн нэгдмэл байдал чухал байна.

Иймд ҮСХ нь бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах үе шатнаас эхлэн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран тодорхойлох, нэгдсэн арга зүйгээр хангах чиглэлд оролцоогоо нэмэгдүүлэх нь бодлогын хэрэгжилтийг чанарын болон тоон үзүүлэлтээр бодитоор дүгнэх боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Салбарын хууль, эрх зүйн орчны талаар:

Статистикийн тухай хуульд албан ёсны статистикийн үзүүлэлтүүд, түүнчлэн тооллого, судалгааны хүрээ, давтамж, хугацааг нарийвчлан зохицуулсан нь статистикийн үйл ажиллагааны тогтвортой байдал, мэдээллийн тасралтгүй байдлыг хангах, урьдчилан төлөвлөх, төсөв, хүний нөөцийг оновчтой хуваарилах зэрэг олон давуу талыг бүрдүүлж байна.

Үүний зэрэгцээ энэхүү нарийвчилсан зохицуулалт нь статистикийн байгууллагын үйл ажиллагааны уян хатан байдлыг зарим талаар хязгаарлах нөхцөл болж байна. Ялангуяа нийгэм, эдийн засаг, технологийн өөрчлөлт хурдацтай явагдаж буй өнөөгийн нөхцөлд шинээр үүсэж буй мэдээллийн хэрэгцээнд шуурхай хариу үйлдэл үзүүлэх, статистикийн

мэдээллийг цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байна. Зарим тохиолдолд бодит хэрэгцээ, ач холбогдол багатай болсон тооллого, судалгаа хуульд заасан үндэслэлээр үргэлжлэн хэрэгжиж байгаа нь мэдээллийн үр ашиг, нөөцийн оновчтой хуваарилалтад нөлөөлөх эрсдэлтэй байна. Ийм нөхцөлд тооллого, судалгааны үр дүнгийн бодит хэрэглээг үнэлэх, үр дүнг ашигласан байдал буюу хэрэглээг тооцох нь чухал ач холбогдолтой юм.

Статистикийн тухай хууль 1997 онд батлагдаж, тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөлд статистикийн тогтолцооны эрх зүйн суурийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн боловч батлагдсанаас хойш 29 жилийн хугацаанд 22 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон нь салбарын суурь зохицуулалт, үзэл баримтлалыг иж бүрэн шинэчлэхэд чиглээгүй, харин тодорхой асуудлыг хэсэгчлэн зохицуулах шинжтэй өөрчлөлтүүд хийгдэж ирсэн байна.

Нөгөө талаас дэлхий нийтэд статистикийн салбар дижитал шилжилт, өгөгдлийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан шинжилгээ, бодит цагийн өгөгдөл ашиглалт зэрэг шинэ чиг хандлагаар эрчимтэй хөгжиж байгаа энэ үед одоогийн үйлчилж буй Статистикийн тухай хууль эдгээр хөгжлийн шаардлага, эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэхгүй, зарим талаар хоцрогдож байгаа тал ажиглагдаж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд, шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит үр нөлөө, тулгамдаж буй асуудал, практикт үүсэж буй хүндрэл, бэрхшээл, зэрэг, сөрөг нөлөөллийг цогцоор нь тодорхойлж, улмаар цаашид хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлохоор зохицуулсан хэдий ч тус хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна. Ийм үнэлгээ хийгдсэнээр хуулийн бодит үр нөлөө, тулгамдаж буй асуудал, практикт үүсэж буй хүндрэл, зэрэг, сөрөг нөлөөллийг цогцоор нь тодорхойлох, улмаар эрх зүйн орчныг шинэчлэх үндэслэл бүрдэх боломжтой.

Мөн олон улсын байгууллагаас Монгол Улсын статистикийн тогтолцоонд хийсэн үнэлгээний тайланд Статистикийн тухай хуулийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны статистикийн үндсэн зарчим болон холбогдох олон улсын стандарт, сайн туршлагад нийцүүлэн иж бүрэн шинэчлэх, албан ёсны чанартай статистикийн мэдээллийг цаг үеийн эрэлт хэрэгцээнд тасралтгүй нийцүүлэх, илүү чанартай, найдвартай, албан ёсны статистик мэдээллийг боловсруулах, үр дүнтэй, үр ашигтай үндэстний статистикийн системийг бий болгох, олон улсын стандартад нийцүүлэх, уялдаа холбоог сайжруулах зорилгоор хууль, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай талаар удаа дараа зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хууль, эрх зүйн орчны шинэчлэл удаашралтай байгаа нь статистикийн байгууллагын үйл ажиллагааг уламжлалт мэдээлэл цуглуулах, боловсруулах чиг үүрэгт төвлөрөхөд нөлөөлж, улмаар өгөгдлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, олон эх үүсвэрийн өгөгдлийг уялдуулах, цаг үеийн шуурхай мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих чиглэлд цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Түүнчлэн ҮСХ-ноос тайлант онд салбарын хэмжээнд мөрдөж буй хууль, дүрэм, журам, зааврын нийцэл, уялдаа, давхардал, зөрчлийг тодорхойлох зорилгоор хийсэн хяналт шалгалтаар нийт 60 баримт бичгээс 38 (63.3 хувь)-д нэмэлт, өөрчлөлт оруулах, 10 (16.7 хувь)-ыг шинэчлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Уг шалгалтаар зарим журам хэрэгжих боломжгүй, холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөх, шинэчлэлттэй уялдаагүй, баримт бичгүүдийн хоорондын уялдаа сул, хяналт, хариуцлагын зохицуулалт дутуу зэрэг нийтлэг алдаа, зөрчил илэрсэн байна.³

Энэ нь статистикийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, зааврын нийцэл, уялдаа хангалтгүй, зарим баримт бичгийн агуулга хоорондоо давхардсан, хэрэгжилтийн зохицуулалт тодорхой бус, мөн шинэчлэгдсэн хууль тогтоомжтой нийцээгүй зохицуулалт нэлээдгүй байгаа нь статистикийн салбарын эрх зүйн орчныг хэсэгчлэн бус, харин нэгдсэн бодлого, уялдаа холбооны хүрээнд цогцоор нь шинэчлэх, мөрдөж буй

³Салбарын хэмжээнд мөрдөж буй хууль, дүрэм, журам, зааврын нийцэлд хийсэн хяналт шалгалтын тайлан, ҮСХ, 2025 он.

баримт бичгүүдийн зохицуулалтыг давхардалгүй, хэрэгжих боломжтой байдлаар шинэчлэх шаардлага байгааг харуулж байна.

Мөн одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд ҮСХ-ны үйл ажиллагаа нь албан ёсны статистикийн гүйцэтгэлийг хангах болон зөвхөн хуульд заасан тооллого, судалгааг гүйцэтгэхэд төвлөрч байгаа нь хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ судалгаа, тооллого, мэдээллийг санаачлах, хөгжүүлэх, өргөжүүлэх боломжийг тодорхой хэмжээнд хязгаарлаж байна. Иймд олон улсын сайн туршлага, зөвлөмжид тулгуурлан статистикийн үйл ажиллагааг илүү уян хатан, хэрэглэгч төвтэй байдлаар хөгжүүлэх боломжийг хууль, эрх зүйн шинэчлэлд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хүний нөөцийн хөгжлийн хүрээнд албан хаагчдын цалин, урамшуулал, ажиллах нөхцөлийг сайжруулж, өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюуны чиглэлээр чадавхыг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулсан, байгууллагын бүтэц, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн байна.

Нөгөө талаас орон нутаг дахь ҮСХ-ны албан хаагчдын цалин хөлс ижил түвшний бусад байгууллагуудтай харьцуулахад доогуур түвшинд байна. Тухайлбал, УИХ-аас удирдлага нь томилогддог орон нутаг дахь нэгжтэй Үндэсний аудитын газрын ижил албан тушаалын цалинтай харьцуулахад сарын нийт цалин 1,381.8 - 1,923.2 мянган төгрөгөөр, харин тухайн шатны Засаг даргын Тамгын газрын ижил албан тушаалын цалинтай харьцуулахад 153.1-203.3 мянган төгрөгөөр тус тус бага байна.

Энэ нь мэргэжлийн болон мэргэшсэн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад сөргөөр нөлөөлж, цаашид хүний нөөцийн бодлого, цалин урамшууллыг оновчтой болгох шаардлагатайг илтгэж байна.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийлээ.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланд гүйцэтгэлийн талаарх эерэг, ерөнхий мэдээлэл давамгайлдаг хандлага нийтлэг ажиглагддаг бөгөөд энэ нь байгууллагын бодит гүйцэтгэлийг бүрэн илэрхийлэхгүй байгаагаас гадна үйл ажиллагааны үр дүнг бодитой хэмжих, сайжруулах үр ашигтай хэрэгсэл болж чадахгүйд хүрдэг. Үр дүн, үр нөлөөг хэмжих үзүүлэлт хангалтгүй тохиолдолд гүйцэтгэлийг ихэвчлэн “хийсэн ажлын хэмжээ”-гээр үнэлэх хандлага бий болж, харин бодит үр дүн, нөлөөллийг тодорхойлох боломж харьцангуй хязгаарлагдмал байдаг.

ҮСХ-ны 2024 болон 2025 оны үйл ажиллагааны тайлангуудыг харьцуулан үзэхэд тайлагналын хэв шинж, ерөнхий бүтцэд төдийлөн өөрчлөлт ороогүй, уламжлалт гүйцэтгэлд суурилсан хэлбэр давамгайлж байна. Тухайлбал, тайлан хэт гүйцэтгэлийн мэдээлэлд төвлөрсөн, өөрөөр хэлбэл хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн ажлын жагсаалт дэлгэрэнгүй тусгагдсан бөгөөд тухайн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, тулгарсан хүндрэл, сургамжийн талаарх мэдээлэл хангалтгүй байна.

Статистикийн байгууллагын үйл ажиллагааны онцлог нь мэдээлэл үйлдвэрлэхээс гадна бодлого боловсруулах, төлөвлөлт хийх, шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан чанартай мэдээллээр хангах явдал юм. Энэ утгаараа статистикийн мэдээллийн үнэ цэнэ нь зөвхөн үйлдвэрлэсэн хэмжээ, хамрах хүрээгээр бус, түүний бодит хэрэглээ, бодлого, шийдвэрт үзүүлэх нөлөөллөөр тодорхойлогдох учиртай.

ҮСХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд албан ёсны статистикийн мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, арга зүйн баримт бичгийг шинэчлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн чиг үүргээ бүрэн хангалттай хэрэгжүүлж, өгөгдлийн дэд бүтэц, мэдээллийн сан, мета өгөгдлийн орчныг бүрдүүлэх, бүртгэлд суурилсан тооллогын арга нэвтрүүлэх, дижитал технологи, цахим систем, хиймэл оюуны туршилтыг ашигласан зэрэг нь статистикийн салбарын шинэчлэлийн бодит үр дүн, ахицыг харуулж байна. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны тайлагнал нь гүйцэтгэлд төвлөрсөн хэвээр

байгаа бөгөөд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлт хангалтгүй байгаагаас бодит үр дүнг хэмжих, үнэлэх боломж хязгаарлагдаж байна.

Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа тайлант оноор дуусгавар болж, нийт хэрэгжилт 82.6 хувь буюу “үр дүнтэй” гэж үнэлэгдсэн байна. Хэдийгээр стратеги төлөвлөгөөний хэрэгжилт тоон үзүүлэлтээр өндөр үнэлэгдсэн боловч зарим зорилт, арга хэмжээний хувьд төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй нь төлөвлөлтийн шатанд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг оновчгүй тодорхойлсон, нөөц боломжид нийцээгүй төлөвлөлт хийсэнтэй холбоотой байна.

Статистикийн салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэл бүрэн хийгдэхгүй, удаашралтай байгаа, мөн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, зааврын нийцэл, уялдаа хангалтгүй, зарим баримт бичгийн агуулга хоорондоо давхардсан, хэрэгжих боломжгүй байгаа нь салбарын эрх зүйн орчныг хэсэгчлэн бус, цогцоор нь шинэчлэх, мөрдөж буй баримт бичгүүдийн зохицуулалтыг давхардалгүй, хэрэгжих боломжтой байдлаар шинэчлэх шаардлагатай байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар мэдээллийн нарийвчлал, хүртээмж, ашиглалтын асуудал хангалтгүй гэсэн үр дүн гарсан боловч уг үр дүнд суурилсан бодит сайжруулалтын арга хэмжээг хангалттай хэрэгжээгүй байна.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, тогтолцоог бүрдүүлж, хяналт шалгалт, дотоод аудитын хүрээнд тайлант онд олон арга хэмжээ хэрэгжүүлсэн хэдий ч хариу арга хэмжээний хэрэгжилтийн түвшин (43 хувь) болон хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил, үл тохирол, сайжруулах шаардлагатай асуудлын тоо харьцангуй өндөр байна.

Хүний нөөцийн чадавхыг сайжруулах хүрээнд хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж, хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан бөгөөд 2024 оноос нэвтрүүлсэн сургалтын цахим системийг ашиглан албан хаагчдыг дотоод, гадаад сургалт, арга хэмжээнд тогтмол хамруулж, шаардлагатай сургалтыг зохион байгуулж байгаа боловч орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын хувьд статистикийн салбарын дэвшилтэт технологид суурилсан ур чадварын хэрэгцээг бүрэн хангахгүй байна.

ҮСХ нь орчин үеийн статистикийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэхээр нэлээдгүй олон үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч цаашид хууль, эрх зүйн орчны шинэчлэл, төрийн байгууллага хоорондын уялдаа, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл үйлдвэрлэл, хүний нөөцийн чадавх, ялангуяа орон нутгийн албан хаагчдын ур чадвар ба цалин урамшууллын асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

Иймд ҮСХ нь гүйцэтгэлд суурилсан тайлагнал, төлөвлөлтөөс үр дүн, үр нөлөөнд суурилсан тогтолцоонд үе шаттай шилжиж, хууль эрх зүйн орчин, хүний нөөц, өгөгдлийн засаглал, хэрэглэгчийн хэрэгцээнд чиглэсэн мэдээллийн чанарыг цогцоор нь сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Дүн шинжилгээнд үндэслэн цаашид ҮСХ-ны үйл ажиллагааг сайжруулах, тайлангийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг хэмжиж, дүгнэх зорилгоор дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд:

Олон улсын стандарт, статистикийн хөгжлийн чиг хандлага, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах, салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа баримт бичгүүдийн нийцэл, уялдаа, давхардлыг арилгах буюу хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах.

Стратеги төлөвлөлтийн чанарыг сайжруулах хүрээнд:

Дараагийн стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх стратеги төлөвлөгөөний явцад гарсан алдааг давтахгүй байхад анхаарч, зорилт, арга хэмжээний уялдаа, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бодит нөөц, санхүүжилт, хэрэгжих боломжтой уялдуулан оновчтой тодорхойлж, хэрэгжилтийг бодитоор хэмжих нөхцөлийг бүрдүүлэх.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг бодит сайжруулалтын арга хэмжээтэй уялдуулах:

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд гарсан статистикийн мэдээллийн нарийвчлал, задаргаа, шуурхай байдлын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилт, үр дүнг тайлагнах.

Цалин, урамшууллын тогтолцоог оновчтой болгох хүрээнд:

Орон нутаг дахь ҮСХ-ны албан хаагчдын цалин хөлс ижил түвшний байгууллагуудтай харьцуулахад бага байгаа асуудлыг шийдвэрлэх хүрээнд ажлын ачаалал, чиг үүрэг, шаардлагатай ур чадварт нийцсэн цалин, урамшууллын зохистой тогтолцоог бүрдүүлэх асуудлыг судалж, үе шаттай шийдвэрлүүлэх.

Хүний нөөцийн бодлогыг бэхжүүлэх хүрээнд:

Орон нутагт ажиллаж буй албан хаагчдын ур чадварыг дэвшилтэт техник технологи, өгөгдлийн шинжилгээ, дижитал статистикийн чиглэлээр зорилтот сургалтаар үе шаттай чадавхжуулж, мэргэшсэн хүний нөөцийг тогтвортой хадгалах бодлогыг хэрэгжүүлэх.

Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх:

Эрсдэлийн хариу арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулж, дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, үл тохирлыг арилгахад тогтмол хяналт тавин, давтан илрэх зөрчлийг бууруулах.

Үйл ажиллагааны тайлагналыг үр дүн, үр нөлөөнд суурилсан байдалд үе шаттай шилжүүлэх:

Үйл ажиллагааны тайланд хэрэгжүүлсэн ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлээс гадна үр дүн, үр нөлөөнд суурилсан тогтолцоонд үе шаттай шилжиж зэрэг болно.

--- оОо ---